



**ЭРДЭНЭС АЛТ**

**РЕСУРС**

**“ЭРДЭНЭС СИЛВЕР РЕСУРС” ХХК**

**“КАТЕРИНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ” АВАХ ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

Тендер шалгаруулалтын нэр: *Катерингийн үйлчилгээ авах тендерийн баримт бичиг*

Тендер шалгаруулалтын дугаар: ЭАРХХК/20240101149

**2024 он**

# I БҮЛЭГ.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА

## А.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

### 1. Тендерийн цар хүрээ

1.1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “Хууль” гэх)-ийн дагуу өгөгдлийн хүснэгтэд заасан захиалагч III бүлэгт тодорхойлсон үйлчилгээ (цаашид “үйлчилгээ” гэх) худалдан авахаар тендер шалгаруулалтыг зохион байгуулна. Тендер шалгаруулалтын нэр болон дугаарыг өгөгдлийн хүснэгтэд заана.

1.2.Тендер шалгаруулалт багцтай бол энэ тухай мэдээллийг өгөгдлийн хүснэгтэд заана.

1.3.Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа үед энэ тухай өгөгдлийн хүснэгтэд заана.

### 2. Санхүүжилтийн эх үүсвэр болон төсөвт өртөг

2.1.Тендер шалгаруулалтын нийт болон багц тус бүрийн санхүүжилтийн эх үүсвэр, батлагдсан төсөвт өртгийг өгөгдлийн хүснэгтэд тусгана.

### 3. Худалдан авах ажиллагааны хууль тогтоомж

3.1.Энэ худалдан авах ажиллагаанд хуулийн 2.1-д заасан төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.

### 4. Худалдан авах ажиллагааны цахим систем

4.1.Тендер шалгаруулалтыг Сангийн сайдын баталсан “Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам”-ын дагуу худалдан авах ажиллагааны цахим систем ([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn)) /цаашид “цахим систем” гэх/-ээр зохион байгуулна.

### 5. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх

5.1.Захиалагч, сонирхогч этгээд, оролцогч болон хуулийн 52.1-д заасан ажилтан, албан тушаалтан Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулиар хориглосон үйлдэл, эс үйлдлийн талаар холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад хууль тогтоомжийн дагуу мэдэгдэнэ.

5.2.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20, 20<sup>1</sup>, 21 дүгээр зүйлд заасан хориглолт, хязгаарлалтад хамаарах этгээд тендер шалгаруулалтад оролцох эрхгүй байна.

### 6. Сонирхогч этгээд, оролцогчид тавигдах ерөнхий шаардлага

6.1.Аж ахуй эрхлэгч нь хуулийн 22.10-т зааснаар үйлчилгээний хураамж төлснөөр тус тендер шалгаруулалтын сонирхогч этгээд болно.

6.2.Сонирхогч этгээдийн төлсөн үйлчилгээний хураамжийг аливаа үндэслэлээр буцаан олгохгүй.

6.3.Оролцогчтой холбоотойгоор хуулийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй буюу ерөнхий шаардлагыг хангасан

байна.

6.4.Оролцогч хуулийн 6 дугаар зүйлд нийцүүлэн тендер ирүүлнэ.

6.5.Тендер шалгаруулалтад оролцох гадаадын этгээд үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу эцсийн өмчлөгчөөр бүртгэгдсэн этгээдийн мэдээллийг ирүүлнэ.

6.6.Монгол Улсын хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд зааснаар бүртгүүлсэн мэдээлэлд үндэслэнэ.

6.7.Монгол Улсын олон улсын гэрээнд үл нийцэх, худалдааны хоригт хамаарах этгээд тендер ирүүлэх эрхгүй.

## **7. Туслан гүйцэтгэгч, түншлэлд тавигдах шаардлага**

7.1.Тендерт ирүүлэх түншлэлийн гэрээ, туслан гүйцэтгүүлэх гэрээ нь хуулийн 6 дугаар зүйлд заасан шаардлага хангасан байна.

7.2.Туслан гүйцэтгүүлэх гэрээ хуулийн 6.4-т заасныг зөрчсөн бол захиалагч тухайн туслан гүйцэтгүүлэх гэрээ, туслан гүйцэтгэгчид холбогдох баримт бичгийг тендер хянан үзэхэд харгалзан үзэхгүй.

7.3.Түншлэлийн болон туслан гүйцэтгэгчийн хувиар оролцохыг зөвшөөрсөн болохыг түншлэлийн гишүүн болон туслан гүйцэтгэгч цахим системээр баталгаажуулсан байна.

7.4.ТШЗ-ны 7.3-т заасан нь гадаадын этгээд түншлэлийн гишүүн, эсхүл туслан гүйцэтгэгчээр ороход хамаарахгүй.

7.5.Түншлэлийн гишүүн, туслан гүйцэтгэгч тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэгдсэн хугацаа дуусгавар болоогүй бол ерөнхий шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.

## **Б.АГУУЛГА**

### **8. Тендер шалгаруулалтын баримт бичиг**

8.1.Тендер шалгаруулалтын баримт бичиг нь доор дурдсан бүлэг болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөс бүрдэнэ:

I Бүлэг. Тендер шалгаруулалтын зааварчилгаа;

II Бүлэг. Өгөгдлийн хүснэгт;

III Бүлэг. Техникийн тодорхойлолт, тавигдах шаардлага;

IV Бүлэг. Тендерийн үнэлгээний шалгуур үзүүлэлт;

V Бүлэг. Тендерийн жишиг маягт;

VI Бүлэг. Гэрээний нөхцөл.

8.2.Сонирхогч этгээд ТШЗ, өгөгдлийн хүснэгтэд заасан шаардлага, шалгуур үзүүлэлт, гэрээний нөхцөл, тендерийн жишиг маягт, техникийн тодорхойлолт болон түүнд оруулсан аливаа өөрчлөлт, иш татсан хууль, журам, зааврыг судалж, тэдгээрт нийцүүлэн тендер бэлтгэнэ.

### **9. Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах**

9.1.Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичигт заасан асуудлаар тодруулга авах бол энэ тухай хүсэлтийг тендерийн нээлтээс ажлын таваас доошгүй өдрийн өмнө бичгээр захиалагчид гаргаж болно.

9.2.Тодруулга авах хүсэлтийг өгөгдлийн хүснэгтэд заасан хаягаар хүлээн авна.

9.3.Тодруулга авах хүсэлтэд үйлчилгээний хураамж төлсөн баримтыг хавсаргана.

9.4.Захиалагч тодруулга авах хүсэлтийн хариуг албан бичгээр үйлдэж, цахим системд нийтэлснээр хүргүүлсэн гэж тооцно.

9.5.Захиалагч тодруулгын үр дүнд тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл ТШЗ-ы 11-д заасныг мөрдөнө.

#### **10. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт**

10.1. Хуулийн 19.4-т зааснаар уулзалт зохион байгуулах, эсхүл ажлын талбайтай танилцуулах бол Өгөгдлийн хүснэгтэд заана.

10.2. Уулзалтад сонирхогч этгээд, түүний төлөөлөл оролцоно.

10.3. ТШЗ-ны 10.1-д заасан уулзалтад оролцоогүй аж ахуй эрхлэгч тендер шалгаруулалт шалгаруулалтад оролцож болно.

#### **11. Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах**

11.1. Тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө захиалагч тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

11.2. Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулсан бол түүнийг цахим системд нийтэлснээр хүчинтэйд тооцогдоно.

11.3. Хэрэв тендер нээхээс ажлын таван өдрийн дотор тендер шалгаруулалтын баримт бичигт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг оруулсан бол тендер хүлээн авах эцсийн хугацааг ажлын таваас доошгүй өдөр байхаар тооцож, шаардлагатай хугацаагаар сунгана.

### **В. ТЕНДЕР БЭЛТГЭХ**

#### **12. Тендер шалгаруулалтын баримт бичгийн болон тендерийн хэл**

12.1. Тендер шалгаруулалтын зарлал, баримт бичиг, урилгыг гадаад хэлээр давхар нийтэлсэн эсэхээс үл хамааран тендер шалгаруулалтын баримт бичиг, тендер шалгаруулалттай холбогдох албан бичиг, захидал, бусад баримт бичиг, оролцогчийн ирүүлэх тендер монгол хэлээр байх ба өөр хэлээр үйлдсэн тендер, түүний доторх баримт бичиг, мэдээллийг орчуулсан орчуулгыг тендерт оролцогч бэлтгэн ирүүлнэ.

12.2. Зөвхөн гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх үйлчилгээ авах тендер шалгаруулалтын хувьд Монгол Улсын олон улсын гэрээг үндэслэн хэлийг өгөгдлийн хүснэгтэд өөрөөр зааж болно.

12.3. Хэрэв ТШЗ-ны 12.2-т зааснаар бэлдсэн тохиолдолд тендер шалгаруулалтын баримт бичгийн монгол хэл болон гадаад хэлээр бэлтгэсэн хувилбар хоорондоо зөрвөл монгол хэлээр бэлтгэсэн хувилбарыг баримтална.

12.4. Тендер хянан үзэх, үнэлэхэд захиалагч гадаад хэлээр үйлдсэн баримт бичгийн орчуулгыг үндэслэх ба оролцогч өөрөө, эсхүл бусад этгээд орчуулсан эсэхээс үл хамааран үнэн зөв, зөрүүгүй болохыг захиалагчийн өмнө хариуцна.

### **13. Тендерийн иж бүрдэл**

13.1. Тендер нь хуулийн 21.1-д нийцүүлж бэлтгэсэн үйлчилгээ үзүүлэх техникийн болон үнийн санал байна.

13.2. Оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер дараах баримт бичиг, мэдээллээс бүрдэнэ:

13.2.1. ТШЗ-ны 14-т заасны дагуу бэлтгэсэн маягтууд;

13.2.2. оролцогчийн итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдээс өөр этгээд тендерийг баталгаажуулсан бол холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн олгосон итгэмжлэл /гадаадын этгээдийн хувьд итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг нотлох баримт/;

13.2.3. ТШЗ-ны 15-д заасны дагуу бэлтгэсэн хувилбарт санал;

13.2.4. оролцогч ТШЗ-ны 16-д заасан ерөнхий шаардлагыг хангасан болохыг нотлох баримт бичиг;

13.2.5. тендерт оролцогчийн чадавх, туршлага ТШЗ-ны 17, 18, 19-д заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангахыг нотлох баримт бичиг;

13.2.6. санал болгож буй үйлчилгээ ТШЗ-ны 20-д заасан шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг;

13.2.7. ТШЗ-ны 21-д заасан үйлчилгээ үзүүлэх төсөв;

13.2.8. ТШЗ-ны 21.5-д заасан тохиолдолд холбогдох тайлбар;

13.2.9. Түншлэлээр, эсхүл туслан гүйцэтгэгчтэй бол холбогдох гэрээ.

13.3. Оролцогч өөрийн тендерийн бүх баримт бичиг, мэдээллийн хүчинтэй байдлыг нягтлах үүрэгтэй бөгөөд үнэн зөвийг захиалагчийн өмнө хариуцна.

13.4. Оролцогч хуулийн 22.7, 22.10-т заасныг үндэслэн тендерийн баталгаа хүргүүлж, үйлчилгээний хураамж төлснөөр тендер илгээнэ.

### **14. Тендерийн жишиг маягтууд**

14.1. Оролцогч V бүлэгт заасан маягтын мэдээллийг хуулийн 21.1.3-т зааснаар цахим системд үүсгэсэн маягтад бөглөж, илгээнэ.

### **15. Хувилбарт санал**

15.1. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол хуулийн 11.10-т заасан шаардлагад нийцэх хувилбарт саналыг тендерийн хамт ирүүлж болно.

### **16. Ерөнхий шаардлагыг магадлах баримт бичиг**

16.1. Оролцогчийн ерөнхий шаардлага хангасан эсэхийг дараах баримт бичгээр магадлана. Үүнд:

16.1.1. ТШЗ-ны 14.1-д заасны дагуу бөглөж ирүүлсэн V бүлгийн Маягт 1.

16.1.2. Ерөнхий шаардлагыг хангасан эсэхийг магадлахтай холбоотой ирүүлэх бусад баримт бичгийг хуулийн 7 дугаар зүйлд нийцүүлэн өгөгдлийн хүснэгтэд заана.

16.2. Гадаадын этгээд нь үүсгэн байгуулагдсан, эсхүл

оршин суугаа улсын төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан дараах баримт бичиг, эсхүл түүнтэй адилтгах баримт бичгийг ирүүлнэ:

16.2.1. хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ, түүнийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг тодорхойлох баримт бичиг;

16.2.2. гадаадын иргэн, харьяалалгүй хүн бол паспорт, түүнийг орлох баримт бичиг;

16.2.3. тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар тухайн улсын хуулиар татварын хугацаа хэтэрсэн өргүй болохыг нотлох баримт бичиг.

16.3. Захиалагч оролцогчийн ерөнхий нөхцөлийг магадлах зорилгоор зөвхөн ТШЗ-ны 16.1, 16.2.2-т заасан баримт бичгээс бусад баримт бичгийг ирүүлэхийг оролцогчоос шаардахгүй ба шаардлагатай бусад нөхцөлийг оролцогчийн ирүүлсэн мэдэгдэл, хуулийн 15.2-т заасан мэдээлэлд үндэслэн магадална.

16.4. Түншлэлийн гишүүн тус бүр ТШЗ-ны 16.1, 16.2-т заасан баримт бичиг ирүүлнэ.

#### **17. Чадавхын болон туршлагын шаардлага**

17.1. Захиалагч ТШЗ-ны 18, 19-д заасан чадавхын болон туршлагын шаардлага тогтооход хуулийн 15 дугаар зүйлийг баримтална.

17.2. Хуулийн 15.2-т заасан цахим системээр дамжуулан шалгах боломжтой, олон нийтэд нээлттэй мэдээллийг нотлох баримтаар ирүүлэхгүй.

**17.3.** Түншлэлийн хувьд төлөөлөх эрх бүхий гишүүн, гишүүн хамтдаа ТШЗ-ны 18, 19-д заасан чадавхын болон туршлагын шаардлагыг бүрэн хангасан байна.

17.4. Түншлэлийн төлөөлөх эрх бүхий гишүүн ТШЗ-ны 18, 19-д чадавхын болон туршлагын шаардлагын 40-аас дээш хувийг, түншлэлийн гишүүн тус бүр 25 ба түүнээс дээш хувийг хангасан байна.

17.5. Туслан гүйцэтгэгч нь энэ зүйлд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийн өөрт холбогдох хэсгийг хангаж байгааг нотлох баримт бичгийг тендерт ирүүлнэ.

#### **18. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт**

18.1. Хуулийн 16.5-д зааснаар оролцогч өгөгдлийн хүснэгтэд заасан санхүүгийн чадавхын шаардлага хангасан байна.

18.2. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 16.2, 16.4-т заасан баримт бичгээс сонгож өгөгдлийн хүснэгтэд заана.

18.3. Оролцогчийн дансны мэдээлэл, түүний үлдэгдлийн талаар харилцагч банкны мэдэгдлээс бусад банк, санхүүгийн байгууллагын мэдэгдлийг оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд харгалзан үзэхгүй. Захиалагч энд зааснаас бусад асуудлаар харилцагч банкны тодорхойлолт ирүүлэхийг шаардахгүй.

18.4. Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх

талаар лавлагааг Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан этгээдээс цахим системээр авч, тендерт ирүүлэх ба уг асуудлаар банк, санхүүгийн байгууллагаас лавлагаа ирүүлэхийг шаардахгүй.

### **19. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт**

19.1.Хуулийн 17.4-т зааснаар оролцогч өгөгдлийн хүснэгтэд заасан техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангасан байна.

19.2.Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 17.2.1, 17.2.3, 17.2.4-т заасан баримт бичгээс сонгож өгөгдлийн хүснэгтэд заана.

19.3.Үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай зөвшөөрөл, эсхүл гэрчилгээ байгаа бол өгөгдлийн хүснэгтэд заана.

19.4.ТШЗ-ны 19.3-т заасан тусгай зөвшөөрлийн шаардлагыг түншлэлийн гишүүн тус бүр хангасан байна. Хэд хэдэн зөвшөөрөл, гэрчилгээ шаардсан бол түншлэлийн гишүүд хамтдаа бүрэн хангасан байна.

### **20. Санал болгож буй үйлчилгээ шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг**

20.1.Санал болгож буй үйлчилгээ нь III бүлэгт заасан техникийн тодорхойлолт, тавигдах шаардлагад нийцсэнийг нотлох баримтыг тендерт ирүүлнэ.

20.2.III бүлэгт заасан техникийн тодорхойлолтын аль нэг зүйлээс зөрүүтэй, орхигдуулсан бол энэ тухай тайлбарыг ирүүлнэ.

20.3.Үйлчилгээ үзүүлэхтэй холбоотойгоор тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдээс бараа, үйлчилгээ авахаар санал болгосон бол шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.

### **21. Тендерийн үнэ ба үнийн хөнгөлөлт**

21.1.Оролцогчийн санал болгож буй үнэ, үнийн хөнгөлөлт нь энэ зүйлд заасан шаардлагад нийцсэн байна.

21.2.Үнийн задаргаанд тусгайлан тусгасан эсэхээс үл хамааран тендерийн үнэд хуулийн 27.13-т заасан зардлыг багтсанд тооцно.

21.3.Үнийн хөнгөлөлт санал болговол үнийн хөнгөлөлт тооцсоны дараах үнийг “тендерийн үнэ” гэж үзнэ.

21.4.Хууль болон өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол оролцогчийн санал болгосон үнэ нь гэрээний хэрэгжилтийн явцад тогтмол байх бөгөөд тохируулга хийхгүй. Тохируулга хийх нөхцөлтэй үнэ санал болгосон тендерийг шаардлага хангаагүй гэж үзнэ. Өгөгдлийн хүснэгтэд үнийн тохируулга хийхийг зөвшөөрсөн тендер шалгаруулалтад тогтмол үнэ санал болгосон тендер ирүүлсэн нь тендерээс татгалзах үндэслэл болохгүй ба үнийн тохируулга нь гэрээний хэрэгжилтийн явцад тэгтэй тэнцүү гэж үзнэ.

21.5.Хуулийн 21.5-д заасан тохиолдолд тендер шалгаруулалтын оролцогчийн тендерийн үнэ төсөвт өртгийн 80 хувиас доош бол уг үнэ нь үйлчилгээний хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхгүй талаар үндэслэл бүхий тайлбарыг тендерт

ирүүлнэ.

## **22. Тендерийн валют**

22.1. Монгол Улсын олон улсын гэрээ болон хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол тендерийн үнийг Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4.1, 4.2-т заасны дагуу үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэхээр заана.

## **23. Тендер хүчинтэй байх хугацаа**

23.1. Оролцогч хуулийн 21.1.1-д заасны дагуу тендер нээснээс хойш өөрийн тендер хүчинтэй байх хугацааг ажлын 30-аас багагүй өдөр байхаар маягт 1-д заана.

23.1. Захиалагч хуулийн 28.8-д зааснаар тендер хүчинтэй байх хугацаа сунгах хүсэлт гаргасан бол оролцогч өөрийн ТШЗ-ны 23.1-д заасан хугацааг сунгаж болно.

23.2. Оролцогч тендерийн хүчинтэй байх хугацааг сунгасан бол ТШЗ-ны 24-т заасан тендерийн баталгааны хүчинтэй байх хугацаа мөн адил тендерийн баталгааны нөхцөлийн дагуу сунгагдахыг баталгаа гаргагч болон оролцогч хариуцна.

23.3. Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж буй тохиолдолд оролцогчийн тендерийн хүчинтэй байх хугацаа нь тухайн ажлын санхүүжилтийн эх үүсвэр батлагдсаны дараа гэрээ байгуулах хүртэл хугацаанд хүчинтэй байхаар заана.

## **24. Тендерийн баталгаа**

24.1. Захиалагч хуулийн 14.1-д заасан тохиолдолд төсөвт өртгийн 0.5 хувиар тооцсон “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцсэн тендерийн баталгаа ирүүлэхийг өгөгдлийн хүснэгтэд заана.

24.2. Хуулийн 14.6-д зааснаар дараах тохиолдолд тендерийн баталгааг хуульд заасан хувь, хэмжээгээр улсын орлого болгоно. Үүнд:

24.2.1. ТШЗ-ны 23-т заасан тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө өөрийн тендерээс бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн татгалзсан;

24.2.2. гэрээ байгуулах эрх авсан оролцогч гэрээ байгуулах, эсхүл гүйцэтгэлийн баталгаа ирүүлээгүй;

24.2.3. Захиалагчийн шийдвэртэй холбогдуулан Сангийн яаманд гаргасан гомдлыг бүхэлд нь үндэслэлгүй гэж шийдвэрлэсэн.

24.3. Тендер шалгаруулалтыг багцад хуваасан бол тендерийн баталгааг багц тус бүрд ирүүлнэ.

24.4. Түншлэлийн хувьд түүнийг төлөөлөх эрх бүхий гишүүн тендерийн баталгааг ирүүлнэ.

## **Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ**

### **25. Тендер баталгаажуулах, илгээх**

25.1. Тендерийг хуулийн 22.1-д зааснаар баталгаажуулан, тендерийн баталгаа шаардсан тохиолдолд тендерийн баталгааг ТШЗ 24-т зааснаар илгээнэ.

25.2. ТШЗ-ны 25.1-д заасны дагуу баталгаажуулсан этгээд оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд бол итгэмжлэл ирүүлэх шаардлагагүй.

25.3. Оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд тендерийг тоон гарын үсгээр баталгаажуулсан бол



V бүлэгт заасан маягтыг ТШЗ-ны 25.1-д зааснаар тамга, тэмдгээр баталгаажуулсан гэж үзнэ. Энэ тохиолдолд маягтыг баталгаажуулахтай холбоотой итгэмжлэл үйлдэх, хуулийн этгээдийн тамга, тэмдгээр баталгаажуулахыг шаардахгүй.

25.4. Оролцогч хуулийн 22.5-д заасан хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээллийг ил болгохгүйгээр илгээх бол хуулийн 22.6.3-т заасан мэдэгдлийг V бүлгийн 07-ын дагуу нууцлахгүйгээр ирүүлнэ.

25.5. Хуулийн 22.6-д заасан баримт бичиг, мэдээллийг заавал ил болгож илгээх ба ТШЗ-ны 25.4-т заасан нь тус баримт бичгүүдэд хамаарахгүй. Захиалагч тухайн тендер шалгаруулалтад нэмэлтээр ил болгох баримт бичгийг өгөгдлийн хүснэгтэд заах ба уг баримт бичиг хүний эмзэг мэдээлэл хамаарах бол мэдээллийн эзний зөвшөөрлийг авсны үндсэн дээр тендер илгээнэ.

#### **26. Тендер хүлээн авах эцсийн хугацаа**

26.1. Тендер хүлээн авах эцсийн хугацааг өгөгдлийн хүснэгтэд заана. Огноо, цагийг цахим системийн серверийн цагаар тооцно.

26.2. Захиалагч тендерийн нээлтийг цахим системээр өгөгдлийн хүснэгтэд заасан огноо, цагт зохион байгуулна. Тендерийн нээлтэд оролцогч, эсхүл түүний төлөөлөгч байлцах эрхтэй.

### **Д. ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ**

#### **27. Тендерийн талаар тодруулга авах**

27.1. Захиалагч тендерийн талаар тодруулга авах тохиолдолд хуулийн 25 дугаар зүйлд заасан журмыг баримтална.

#### **28. Тендерийг шаардлагад нийцсэн эсэхийг хянан үзэх**

28.1. Тендерийг хянан үзэхэд хуулийн 26 дугаар зүйлд заасан журам, ТШЗ-ны 13-т заасан тендерийн иж бүрдэл, холбогдох мэдээллийн сангаас илгээсэн мэдээлэл, оролцогч болон түүний тендерийн талаар авсан тайлбар, тодруулгад үндэслэн хянан үзнэ.

#### **29. Тендерийг үнэлэх**

29.1. Захиалагч тендерийг хуулийн 27 дугаар зүйл, Сангийн сайдын “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-ын дагуу үнэлж, харьцуулна.

#### **30. Арифметик алдааг залруулах**

30.1. Тендерийн үнийн арифметик алдааг “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-т зааснаар залруулна.

30.2. ТШЗ-ны 30.1-д заасны дагуу арифметик алдааг залруулсан тухай мэдээллийг оролцогчид хүргүүлнэ.

#### **31. Үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт**

31.1. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол IV бүлэгт заасан үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлж, харьцуулах үнийг хийсвэрээр нэмэгдүүлнэ.

#### **32. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлох**

32.1. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлоход дараах дарааллыг баримтална:

32.1.1. ТШЗ-ны 21.1-д зааснаар санал болгосон тендерийн үнийг тогтоох;

32.1.2. ТШЗ-ны 21.3-д заасны дагуу санал болгосон

үнийн хөнгөлөлт тооцох;

32.1.3. ТШЗ-ны 30.1-д заасны дагуу тендерийн үнэд хийсэн арифметик алдааг залруулах;

32.1.4. ТШЗ-ны 29.1.1, 29.1.2, 29.1.3-т заасан үнийг шаардлагатай бол ТШЗ-ны 22.1-д заасан валютад хөрвүүлэх;

32.1.6. ТШЗ-ны 31.1-д заасан үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлж тооцох.

32.2. ТШЗ-ны 1.2-т заасны дагуу хоёр ба түүнээс дээш багцтай тендер шалгаруулалтад хэд хэдэн багцад хамтад нь хамгийн бага харьцуулах үнэ санал болгосон тендерийг тодорхойлох, түүнд санал болгосон үнийн хөнгөлөлтийг тооцохдоо дараах аргачлалыг баримтална:

32.2.1. багц тус бүрийн хамгийн бага харьцуулах үнэтэй тендерийг сонгох;

32.2.2. хоёр ба түүнээс дээш багцад гэрээ байгуулах эрх авсан тохиолдолд үнийн хөнгөлөлт үзүүлэхээр санал болгосон тендерийн үнээс уг үнийн хөнгөлөлтийг тендер илгээх маягтад тодорхойлсон аргачлалын дагуу тооцсоны дараа шаардлагатай бол түүний харьцуулах үнийг дахин тодорхойлно. Ийнхүү тодорхойлохдоо хоёр ба түүнээс дээш багцад хамгийн бага харьцуулах үнэтэй тендер ирүүлсэн этгээд нь ТШЗ-ны 34-д зааснаар дахин магадлахад шаардлага хангаж байхыг шаардана;

32.2.3. дээрх үнэлгээг хийсний дараа тендерийн харьцуулах үнэд үндэслэн захиалагч гэрээ байгуулах эрхийг нэг багцад, хэд хэдэн багцад, эсхүл бүх багцад олгох хувилбаруудыг тооцож, гэрээний үнийн нийлбэр нь хамгийн бага байх хувилбарыг сонгох.

32.3. ТШЗ-ны 15.1-д зөвшөөрсний дагуу хувилбарт санал ирүүлсэн тендер “хамгийн сайн” гэж үнэлэгдсэн бол түүний хувилбарт саналыг хянан үзэж, үнэлнэ.

32.4. ТШЗ-ны 32.3-т зааснаар тендерийн саналын хувилбарыг хянан үзэх, үнэлэхэд үндсэн тендерийг үнэлсэн журмыг баримтална.

### **33. Тендерийг эрэмбэлэх**

33.1. Захиалагч тендерүүдийг эрэмбэлэхэд хуулийн 27.5, 27.6-д заасныг баримтална.

### **34. Оролцогчийн чадавхыг дахин магадлах**

34.1. Захиалагч хэд хэдэн багцад хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчийг тэдгээр багцад заасан гэрээний үүрэг гүйцэтгэх чадавхтай эсэхийг, мөн санал болгосон хүний нөөц, тоног төхөөрөмжийн мэдээлэл өөр бусад төсөл, арга хэмжээний мэдээлэлтэй давхацсан тохиолдолд дахин магадална.

## II БҮЛЭГ. ӨГӨГДЛИЙН ХҮСНЭЛТ

34.2. ТШЗ-ны 34.1-д заасны дагуу дахин магадлахад зөвхөн ТШЗ-ны 18.1-д заасан санхүүгийн чадавх, ТШЗ-ны 19.1-д заасан техникийн чадавх, туршлага, гэрээний үүрэг гүйцэтгэх чадавхын шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангах эсэхийг тендер хянан үзэхэд ашигласан баримт бичиг, мэдээлэлд үндэслэнэ.

34.3. Оролцогчийн чадавхыг дахин магадалж, хуулийн 27.10-т зааснаар гэрээ байгуулах эрх олгоно.

### Е. МЭДЭГДЭЛ ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ

#### 35. Мэдэгдэл хүргүүлэх

35.1. Захиалагч хуулийн 28 дугаар зүйлд заасан шийдвэрийг хуулийн 24.1-д зааснаар ажлын 15 өдрийн дотор гаргаж, оролцогчдод мэдэгдэнэ.

#### 36. Гүйцэтгэлийн баталгаа

36.1. Хуулийн 42.1-д заасан тохиолдолд гэрээ байгуулах эрх авсан оролцогч тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн гурван хувийн үнийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ.

36.2. Гүйцэтгэлийн баталгаа, урьдчилгаа төлбөрийн баталгааг “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцүүлэн гаргана.

#### 37. Урьдчилгаа төлбөр

37.1. Гэрээг хэрэгжүүлж эхлүүлэхтэй холбогдох зардалд урьдчилгаа төлбөр олгохгүй.

#### 38. Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах

38.1. Захиалагч VI бүлгийн гэрээний нөхцөлийн гэрээ баталгаажуулах маягыг түүнд заасан зааврын дагуу шаардлагатай хэсгийг эцэслэн нөхөж, оролцогчид хүргүүлнэ.

38.2. Захиалагч тендер шалгаруулалтын үр дүнд нийлүүлэгчтэй гэрээ байгуулахад тендер шалгаруулалтын баримт бичгийн VI бүлэг дэх гэрээний нөхцөлийг баримтална.

38.3. Шалгарсан оролцогч ТШЗ-ны 38.1-д зааснаар ирүүлсэн гэрээнд гарын үсэг зурж, баталгаажуулан захиалагчаас шаардсан хугацааны дотор хүргүүлнэ.

38.4. Захиалагч хуулийн 30.4-т зааснаар ажлын 10 өдрийн дотор гэрээг баталгаажуулаагүй бол гэрээ байгуулах шийдвэрт заасан нөхцөлөөр гэрээ байгуулсанд тооцогдоно.

#### 39. Тендер шалгаруулалтын гомдол

39.1. Хууль болон Сангийн сайдын баталсан “Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам”-ын дагуу гомдлыг хянан шийдвэрлэнэ.

ТШЗ-ны холбогдох заалт	<b>А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ</b>
ТШЗ 1.1	Захиалагч: <b>“Эрдэнэс Алт Ресурс” ХХК</b>
ТШЗ 1.1	Тендер шалгаруулалтын нэр: <b>Катерингийн үйлчилгээ</b>
ТШЗ 1.1	Тендер шалгаруулалтын зарлалын дугаар: <b>ЭАРХХК/20240101149</b>
ТШЗ 1.2	Тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <b>Багцгүй.</b>
ТШЗ 1.3	Тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа эсэх: <b>“Үгүй”</b>
ТШЗ 2.1	Санхүүжилтийн эх үүсвэр нь: <b>Өөрийн хөрөнгө</b>
ТШЗ 2.1	Нийт төсөвт өртөг: <b>963,630,000 (Есөн зуун жаран гурван сая зургаан зуун гучин мянга) төгрөг</b>
<b>Б. АГУУЛГА</b>	
ТШЗ 9.1	<p>Тендерийн баримт бичгийн талаар тодруулга авах хаяг: Хүлээн авагчийн нэр: <b>“Эрдэнэс Алт Ресурс” ХХК</b> Хаяг: <b>Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 -р хороо, Блю Скай Тауэр, 6 давхарт 607 тоот</b> Утасны дугаар: <b>75351111 – 1055</b> Цахим шуудангийн хаяг: <b>procurement@erdenesgold.mn</b></p> <p>Сонирхогч этгээд тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга, нэмэлт мэдээллийг тендер хүлээн авах эцсийн хугацаанаас ажлын <b>5-аас доошгүй хоногийн өмнө</b> захиалагчаас авах хүсэлтийг бичгээр гаргаж болно.</p> <p>Тендерийн баримт бичгийн тодруулга, нэмэлт мэдээлэлтэй холбогдуулан захиалагч тендер хүлээн авах эцсийн хугацаанаас ажлын 2-оос доошгүй хоногийн өмнө тендерийн баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах, тендер хүлээн авах эцсийн хугацааг сунгах эрхтэй ба энэ нь тендерийн баримт бичгийн салшгүй нэг хэсэг байна.</p> <p>Захиалагч тодруулгыг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (<a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>)-д нээлттэй байршуулснаар сонирхогч этгээдэд хүргүүлсэнд тооцно.</p> <p>Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичгийн салшгүй хэсэг болох тодруулга, нэмэлт, өөрчлөлтийг тендер хүлээж авах эцсийн хугацаа хүртэл шалган нягталж, түүнд нийцүүлэн тендер бэлтгэх үүрэгтэй.</p>
ТШЗ 10.1	Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт зохион байгуулах эсэх: <b>“Үгүй”</b>
<b>В. ТЕНДЕР БЭЛТГЭХ</b>	

ТШЗ 12.1	Тендер шалгаруулалтын хэл: <b>Монгол хэл</b> <i>Жич: Гадаад хэл дээрх бүх материалыг баталгаат орчуулгын хамт ирүүлнэ.</i>
ТШЗ 15.1	Хувилбарт санал ирүүлэхийг: <b>“Зөвшөөрөхгүй”</b>
ТШЗ 16.1.2	<p>Ерөнхий шаардлагыг магадлахад шаардагдах бусад баримт бичиг: <b>“Шаардана”</b></p> <ol style="list-style-type: none"> <li>1. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг ирүүлэх шаардлагагүй бөгөөд “Төрийн мэдээлэл солилцооны ХУР систем”-ээр дамжуулан шалгана.</li> <li>2. Тендер шалгаруулалт зарласнаас хойш хугацаанд цахим системээс авсан нийгмийн даатгалын шимтгэлийн болон татварын өр төлбөргүй тодорхойлолтыг цахим системийн холбогдох талбараар зааварчилгааны дагуу тус тус ирүүлнэ. Энэхүү тодорхойлолтыг ирүүлээгүй тохиолдолд тендер нээсэн өдрийн байдлаар татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн хугацаа хэтэрсэн өр төлбөрийн талаарх мэдээллийг шалгана.</li> <li>3. Шүүхийн шийдвэрээр иргэн, хуулийн этгээдэд өр, төлбөргүй талаарх хүчин төгөлдөр лавлагааг цахим системээс авч, зааварчилгааны дагуу цахим системээр холбогдох талбараар ирүүлнэ.</li> </ol> <p>Анхааруулга: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт авах хүсэлтийг тендерт оролцогч Худалдан авах ажиллагааны цахим систем (<a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>)-д өөрийн үндэсний тоон гарын үсэг ашиглан тендерийн нээлтээс өмнө хүчин төгөлдөр тодорхойлолтыг тендер илгээх холбогдох хэсэг сонгож цахим хэлбэрээр ирүүлнэ. Түншлэлээр оролцож буй тохиолдолд түншлэлийн төлөөлөх эрх бүхий этгээд нь түншлэлийн гэрээг цахим системд баталгаажуулсны дараа гишүүн этгээдийн хүчин төгөлдөр тодорхойлолтыг тендер илгээх холбогдох хэсэгт сонгож илгээнэ.</p> <ol style="list-style-type: none"> <li>4. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7.1-д заасан нөхцөл үүссэн эсэх мэдэгдлийг бичгээр гаргана баталгаажуулж ирүүлнэ.</li> </ol>
ТШЗ 18.1	<p>Санхүүгийн чадавхын шаардлага: <b>“Шаардана”</b></p> <p><b>Борлуулалтын орлогын хэмжээ: Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр 2021, 2022, 2023 онуудын аль нэг жилд гүйцэтгэсэн нийт борлуулалтын орлогын хэмжээ нь батлагдсан төсөвт өртгийн 80 хувиас багагүй байх.</b></p>
ТШЗ 18.1.2	<p><b>Түргэн хөрвөх хөрөнгийн хэмжээ: Батлагдсан төсөвт өртгийн 40 хувиас багагүй байна. Түргэн хөрвөх хөрөнгийн хэмжээний нийт дүнг дараах шалгуур үзүүлэлтүүдийн аль нэгээр эсвэл нийлбэрээр тус тус тодорхойлно. Үүнд:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Байгууллагын дансны үлдэгдэл /Харилцагч банкны тодорхойлолт/</li> <li>- Арилжааны банкнаас авч болох мөнгөн дүн бүхий судлагдсан зээлжих эрхийн тодорхойлолт /Төсөвт өртгийн 40 хувиас багагүй/</li> </ul>
ТШЗ 18.2	Санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох баримт бичиг:

	<ol style="list-style-type: none"> <li>1. Санхүүгийн тайланг өөрийн тендертээ хавсарган ирүүлэх шаардлагагүй бөгөөд цахим системээр дамжуулан Сангийн яамны цахим санхүүгийн тайлангийн <a href="http://www.e-balance.mof.gov.mn">www.e-balance.mof.gov.mn</a> мэдээллийн системээс тендерт оролцогчдын санхүүгийн тайлангаас сүүлийн 3 жилийн борлуулалтын орлого, болон бусад шаардлагатай мэдээллийг шалгана.</li> <li>2. Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдээс тендер шалгаруулалт зарласан өдрөөс хойш авсан, шалгах боломжтой QR код бүхий “Зээлийн мэдээллийн сангийн тодорхойлолт”-ыг ирүүлнэ. Уг тодорхойлолтод төлөгдөж дуусаагүй зээлийн мэдээлэл “Хэвийн” бус байгаа тохиолдолд татгалзах үндэслэл болно. (“Зээлийн мэдээллийн сангийн тодорхойлолт”-ыг <a href="http://www.sainscore.mn">www.sainscore.mn</a>, <a href="http://www.burenscore.mn">www.burenscore.mn</a> хаягаар хандан авна. Харилцагч банкны тодорхойлолтыг тендерийг хянан үзэхэд харгалзан үзэхгүй.)</li> <li>3. ТШЗ-ын 18.1.2-т заасан шаардлагуудыг хангасан байна.</li> </ol>																																																
<p><b>ТШЗ 19.1</b></p>	<p>Техникийн чадавх болон туршлагын шаардлага: <b>“Шаардана”</b></p> <p>Хийж гүйцэтгэсэн үйлчилгээний нийт мөнгөн дүнг жил жилээр харуулсан жагсаалт ирүүлэх шаардлагатай жилийн тоо: Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр 2021, 2022, 2023 онуудад хийж гүйцэтгэсэн үйлчилгээний жагсаалтыг V дугаар бүлгийн маягт 2-ын дагуу ирүүлнэ.</p>																																																
<p><b>ТШЗ 19.1.2</b></p>	<p>Үйлчилгээ үзүүлэх хүний нөөц: <b>“Шаардана”</b></p> <table border="1" data-bbox="448 1032 1485 1989"> <thead> <tr> <th>№</th> <th>Албан тушаал</th> <th>Хүний тоо</th> <th>Ажилласан жилийн туршлага</th> <th>Мэргэжил мэргэшил</th> <th>Үндсэн ажилтан эсэх</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>1</td> <td>Ерөнхий тогооч</td> <td>1</td> <td>Мэргэжлээрээ 5-аас доошгүй жил</td> <td>Тогооч 1-р зэрэг</td> <td>Тийм</td> </tr> <tr> <td>2</td> <td>Ахлах тогооч</td> <td>2</td> <td>Мэргэжлээрээ 5-аас доошгүй жил</td> <td>Тогооч 1-р зэрэг</td> <td>Тийм</td> </tr> <tr> <td>3</td> <td>Ерөнхий технологич</td> <td>1</td> <td>Мэргэжлээрээ 1-ээс доошгүй жил</td> <td>Мэргэжлийн дипломтой байх</td> <td>Тийм</td> </tr> <tr> <td>4</td> <td>Тогооч</td> <td>4</td> <td>Мэргэжлээрээ 5-аас доошгүй жил</td> <td>Мэргэшлийн үнэмлэхтэй байх</td> <td>Тийм</td> </tr> <tr> <td>5</td> <td>Жолооч</td> <td>1-2</td> <td>Мэргэжлээрээ 5-аас доошгүй жил</td> <td>/B, C/ Ангилалтай байх</td> <td>Тийм</td> </tr> <tr> <td>6</td> <td>Хүнсний эрүүл ахуйч</td> <td>1</td> <td>Мэргэжлээрээ 1-ээс доошгүй жил</td> <td>Мэргэжлийн дипломтой байх</td> <td>Тийм</td> </tr> <tr> <td>7</td> <td>Туслах ажилтан /Бэлтгэгч, үйлчлэгч, Нярав</td> <td>20</td> <td>Мэргэжлээрээ 1-ээс доошгүй жил</td> <td>-</td> <td>Үндсэн эсвэл гэрээт</td> </tr> </tbody> </table> <p>1. Үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой хүний нөөцийн бүрдүүлэлт, зохион байгуулалтыг гүйцэтгэгч тал бүрэн хариуцна.</p>	№	Албан тушаал	Хүний тоо	Ажилласан жилийн туршлага	Мэргэжил мэргэшил	Үндсэн ажилтан эсэх	1	Ерөнхий тогооч	1	Мэргэжлээрээ 5-аас доошгүй жил	Тогооч 1-р зэрэг	Тийм	2	Ахлах тогооч	2	Мэргэжлээрээ 5-аас доошгүй жил	Тогооч 1-р зэрэг	Тийм	3	Ерөнхий технологич	1	Мэргэжлээрээ 1-ээс доошгүй жил	Мэргэжлийн дипломтой байх	Тийм	4	Тогооч	4	Мэргэжлээрээ 5-аас доошгүй жил	Мэргэшлийн үнэмлэхтэй байх	Тийм	5	Жолооч	1-2	Мэргэжлээрээ 5-аас доошгүй жил	/B, C/ Ангилалтай байх	Тийм	6	Хүнсний эрүүл ахуйч	1	Мэргэжлээрээ 1-ээс доошгүй жил	Мэргэжлийн дипломтой байх	Тийм	7	Туслах ажилтан /Бэлтгэгч, үйлчлэгч, Нярав	20	Мэргэжлээрээ 1-ээс доошгүй жил	-	Үндсэн эсвэл гэрээт
№	Албан тушаал	Хүний тоо	Ажилласан жилийн туршлага	Мэргэжил мэргэшил	Үндсэн ажилтан эсэх																																												
1	Ерөнхий тогооч	1	Мэргэжлээрээ 5-аас доошгүй жил	Тогооч 1-р зэрэг	Тийм																																												
2	Ахлах тогооч	2	Мэргэжлээрээ 5-аас доошгүй жил	Тогооч 1-р зэрэг	Тийм																																												
3	Ерөнхий технологич	1	Мэргэжлээрээ 1-ээс доошгүй жил	Мэргэжлийн дипломтой байх	Тийм																																												
4	Тогооч	4	Мэргэжлээрээ 5-аас доошгүй жил	Мэргэшлийн үнэмлэхтэй байх	Тийм																																												
5	Жолооч	1-2	Мэргэжлээрээ 5-аас доошгүй жил	/B, C/ Ангилалтай байх	Тийм																																												
6	Хүнсний эрүүл ахуйч	1	Мэргэжлээрээ 1-ээс доошгүй жил	Мэргэжлийн дипломтой байх	Тийм																																												
7	Туслах ажилтан /Бэлтгэгч, үйлчлэгч, Нярав	20	Мэргэжлээрээ 1-ээс доошгүй жил	-	Үндсэн эсвэл гэрээт																																												

2. Ээлжийн жолооч үндсэн ажилтан байх ба сүүлийн 1 жил тухайн компанид нийгмийн даатгалын шимтгэл төлсөн байх ба тээврийн хэрэгсэл, жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд сүүлийн 6 сар бүрэн хамрагдсан байна.
3. Дээрх ажилтнууд нь тухайн байгууллагын үндсэн ажилтан байх ба дор хаяж 80 хувь нь нийгмийн даатгалын шимтгэлийг сүүлийн 6 сар тухайн тендерт оролцогч аж ахуйн нэгжид тасралтгүй төлсөн болохыг “Төрийн мэдээлэл солилцооны ХУР систем-ээр дамжуулан шалгах тул НД-8 маягтаар гаргасан тайланг ирүүлэх шаардлагагүй.
4. Дээрх ажилтнуудын мэдээллийг худалдан авах ажиллагааны цахим систем [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) -ээр дамжуулан ирүүлнэ. Тендер нээсэн өдөр цахим системээр мэдээллийг татаж шалгана.
5. Хүнсний бараа материалын хангамж, худалдан авалт, зарцуулалтын журамтай байх ба нийлүүлэгчээс хэрэглэгчдэд хүрэх бүх үйл ажиллагааг стандартын дагуу хянах, эрүүл ахуй, чанарт шалгалт хийх мэргэшсэн баг бүрэлдэхүүнтэй байна.
6. Үйлчилгээ үзүүлэхэд зайлшгүй байх багийн удирдах ба голлох ажилтнуудын 80 хувь нь компанийн үндсэн ажилтан байх ба эдгээр ажилчдын гэнэтийн ослын даатгал, амь насны даатгалд 6 сараар хамрагдсан гэрээтэй байх. Гэрээний хуулбарыг тендерийн баримт бичигт хавсарган ирүүлэх.
7. Дээрх ажилтнуудын хүчин төгөлдөр хугацаа бүхий мэргэжлийн диплом, мэргэшлийн үнэмлэхийн хуулбар, захирлын тушаал зэргийг ирүүлэх.
8. Компанийн үндсэн ажилтнаас бусад ажилтнууд нь хөлсөөр ажиллах эсхүл шинэ ажилтнууд байж болох ба хөлсөөр ажиллуулах гэрээ нь зөвхөн тухайн төсөл, арга хэмжээнд зориулан байгуулсан байх шаардлагатай бөгөөд гэрээний хугацаа, болон бусад нөхцөлийг тодорхой тусгасан байна.

**ТШЗ 19.1.3**

Үйлчилгээ үзүүлэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл:  
**“Шаардана**

Машин механизм, тоног төхөөрөмжийн нэр, зориулалт	Хүчин чадал	Тоо ширхэг	“Өөрийн эзэмшил” эсхүл “түрээс”
Хөргүүртэй машин	-	1	Өөрийн эзэмшлийнх
Ажилчид тээвэрлэх тээврийн хэрэгсэл	-	1	Өөрийн эзэмшлийнх
Хог хаягдлын машин	-	1	Өөрийн эзэмшлийн эсвэл түрээс
Хөргүүрт агуулах	50 тн-оос дээш	1	Өөрийн эзэмшлийнх

- Тээврийн хэрэгслийг түрээсээр ашиглах бол түрээсийн гэрээг ирүүлнэ.
- Түрээсийн гэрээг тендер зарласан өдрөөс хойш зөвхөн тухайн төсөл, арга хэмжээнд зориулан байгуулсан байх шаардлагатай бөгөөд

	гэрээний хугацаа, үнийн дүн болон бусад асуудлыг тодорхой тусгасан байх.																				
<b>ТШЗ 19.1.4</b>	<p>Ижил төстэй үйлчилгээ үзүүлсэн туршлага: <b>“Шаардана”</b></p> <p><b>2021, 2022, 2023 онуудын аль нэг жилд батлагдсан төсөвт өртгийн 80 хувиас багагүй үнийн дүнтэй хоол үйлдвэрлэл, катерингийн үйлчилгээ үзүүлэх гэрээний үндсэн гүйцэтгэгчээр доод тал нь нэг удаа ажилласан байх.</b> /Он дамжин хэрэгжсэн гэрээний хувьд гэрээ дүгнэсэн актын огноог үндэслэл болгоно./</p> <ul style="list-style-type: none"> <li>- Үйлчилгээ үзүүлсэн гэрээний хуулбар болон гэрээ дүгнэсэн актын хуулбарыг бүрэн ирүүлнэ.</li> <li>- Тухайн үйлчилгээг цаг хугацаанд нь чанартай хийж гүйцэтгэсэн талаарх захиалагчийн тодорхойлолт ирүүлнэ.</li> <li>- Сүүлийн 3 жилд хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлын жагсаалтыг доорх загварын дагуу ирүүлнэ. Үүнд:</li> </ul> <table border="1" style="width: 100%; border-collapse: collapse;"> <thead> <tr style="background-color: #f4a460;"> <th style="text-align: center;">Гэрээний нэр</th> <th style="text-align: center;">Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас</th> <th style="text-align: center;">Төсөвт өртөг</th> <th style="text-align: center;">Хугацаа /эхэлсэн, дууссан/</th> </tr> </thead> <tbody> <tr><td> </td><td> </td><td> </td><td> </td></tr> <tr><td> </td><td> </td><td> </td><td> </td></tr> <tr><td> </td><td> </td><td> </td><td> </td></tr> <tr><td> </td><td> </td><td> </td><td> </td></tr> </tbody> </table>	Гэрээний нэр	Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас	Төсөвт өртөг	Хугацаа /эхэлсэн, дууссан/																
Гэрээний нэр	Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас	Төсөвт өртөг	Хугацаа /эхэлсэн, дууссан/																		
<b>ТШЗ 19.1.5</b>	Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх шаардлага: <b>“Шаардахгүй”</b>																				
<b>ТШЗ 19.1.6</b>	<p>Техникийн чадавх болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангахыг нотлох бусад шаардлага: <b>“Шаардана”</b></p> <ol style="list-style-type: none"> <li>1.Тендерийн баримт бичгийн өгөгдлийн хүснэгт, гэрээний тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байгаа тухай албан бичиг ирүүлэх.</li> <li>2. Техникийн тодорхойлолтод заасан ажил үйлчилгээг хугацаанд чанартай хийж гүйцэтгэж үр дүнг хүлээлгэн өгөх тухай албан бичиг ирүүлэх.</li> </ol>																				
<b>ТШЗ 19.2</b>	<p>Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг нотлох баримт бичиг: <b>“Шаардана”</b></p> <ol style="list-style-type: none"> <li>1. Байгууллагын дэлгэрэнгүй танилцуулга ирүүлэх.</li> <li>2. Нэг хүн нэг өдрийн нэгж үнээр тооцсон хоол хүнсний үнэ ирүүлэх /Багцын хоолыг өглөө, өдөр, орой, шөнө тус бүрээр ангилан үнийг тус тусад нь тооцож ирүүлнэ./</li> <li>3. Үндсэн үйл ажиллагааны хуваарь /Хоол, хүнсний хангалт, угаалга, цэвэрлэгээ, аж ахуйн засвар үйлчилгээний хуваарийг тус тусад нь тооцож ирүүлнэ./</li> <li>4. Хоол үйлдвэрлэл үйлчилгээний газарт тавигдах MNS 4946:2019 шаардлагыг хангасан байх (Тохирлын гэрчилгээ ирүүлэх)</li> <li>5. Захиалагчийн катерингийн үйлчилгээнд ашиглагдах чанарын шаардлага хангасан эрүүл ахуйн баталгаажуулалт бүхий хүнсний бараа материал, мах, махан бүтээгдэхүүний жагсаалт, танилцуулгыг</li> </ol>																				



	<p>бүтээгдэхүүний зургийн хамт ирүүлэх./Бүтээгдэхүүн нийлүүлэгч байгууллагын гэрээг заавал хавсаргана./</p> <ol style="list-style-type: none"> <li>6. Ээлжийн ажилчдад өгөх дисерт бүтээгдэхүүний жагсаалт бүхий танилцуулгыг бүтээгдэхүүний зургийн хамт ирүүлэх</li> <li>7. ХАБЭА-н аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйд нийцсэн хамгаалалтын, үйлчилгээний хувцас, тоног төхөөрөмж хэрэгсэл, багажаар ажилтан бүрийг хангасан байх. /Зураг танилцуулга ирүүлэх/</li> <li>8. Үйлчилгээтэй холбоотой үйл ажиллагааг хянах, шалгах, мэдээлэл солилцох, бүртгэл, жагсаалт хөтлөх батлагдсан маягтуудтай байх. (загвар ирүүлэх)</li> <li>9. Хортон шавжаас урьдчилан сэргийлэх, устгах хөтөлбөр, журамтай байх.</li> <li>10. Үйл ажиллагаа, ажиллах хүчинтэй холбоотой зохих даатгалуудад бүрэн хамрагдсан байна.</li> <li>11. Ажилчдын гэнэтийн ослын болон амь насны даатгал, тээврийн хэрэгсэл, жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд сүүлийн 6 сар бүрэн хамрагдсан болохыг баталгаажуулсан баримт бичгийг ирүүлнэ.</li> <li>12. Нийт ажилчид нь эрүүл мэндийн үзлэгт бүрэн хамрагдсан байна. /Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/145 тушаал, журмын шаардлагыг хангасан эрүүл мэндийн үзлэгийн хуудсыг ирүүлэх./</li> <li>13. Ажлын даалгаварт заагдсан шаардлагыг бүрэн хангаж ажиллах тухай баталсан албан бичиг ирүүлэх.</li> </ol>
<b>ТШЗ 19.3</b>	<p>Тусгай зөвшөөрөл/зөвшөөрөл: <b>“Шаардахгүй”</b></p> <p>- Үйл ажиллагааны чиглэл нь хоол үйлдвэрлэл байх.</p>
<b>ТШЗ 21.4</b>	<p>Оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад: <b>“Тохируулахгүй тогтмол байна”</b></p>
<b>ТШЗ 24.1</b>	<p>Тендерийн баталгааны дүн: <b>4,818,150 /Дөрвөн сая найман зуун арван найман мянга нэг зуун тавь/ төгрөг</b></p> <p>Тендерийн баталгааны хүчинтэй хугацаа: Тендер хүчинтэй байх хугацаанаас хойш 28 хоног байна.</p>
<b>Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ</b>	
<b>ТШЗ 25.5</b>	<p>Оролцогчдод ил болох баримт бичгийн жагсаалт:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Тендерт оролцогч нь хувь хүний нууцын тухай болон байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь файл үүсгэн ирүүлнэ.</li> <li>- Тус файлын эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн эрх бүхий этгээд баталгаажуулан ирүүлнэ.</li> <li>- Тендерт оролцогч хуульд заасан үндэслэлээр нууцалж буй баримт бичиг, мэдээлэл бүрд хамаарах хууль зүйн үндэслэлийг тодорхой тайлбарласан тайлбарыг V бүлгийн Маягтын дагуу нууцлахгүйгээр ирүүлнэ.</li> <li>- Бүх материалыг нууцалж ирүүлсэн тохиолдолд татгалзах үндэслэл болно.</li> </ul>

### III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

<b>ТШЗ 26.1</b>	Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: Огноо: <b>2024 оны 05 дугаар сарын 20-ны өдөр</b> Цаг: <b>11 цаг 00 минут</b> Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем ( <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> )-ийн серверийн цагаар тооцогдох тул хугацаа хоцорсон тохиолдолд тендерийн материал хүлээн авах боломжгүй.
<b>ТШЗ 26.2</b>	Тендерийн нээлтийг доор дурдсан хугацаанд цахим системээр хийх бөгөөд нээлтийн мэдээллийг оролцогч цахим системээр хүлээн авна. Огноо: <b>2024 оны 05 дугаар сарын 20-ны өдөр</b> Цаг: : <b>11 цаг 30 минут</b> Тендер нээлтэд оролцох боломжтой газрын хаяг: <b>“Эрдэнэс Алт Ресурс” ХХК, Сүхбаатар дүүрэг, 1 -р хороо, Блю Скай Тауэр, 6 давхарт 607 тоот , Улаанбаатар хот</b>
<b>Д. ТЕНДЕРИЙГ ХЯНАН ҮЗЭХ, ҮНЭЛЭХ</b>	
<b>ТШЗ 31.1</b>	Тендер үнэлэх үндсэн шалгуурыг харьцуулах үнээс өөрөөр тогтоох эсэх: <b>“Үгүй”</b>
<b>Е. МЭДЭГДЭЛ ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ</b>	
<b>ТШЗ 36.1</b>	Шалгарсан оролцогч гүйцэтгэлийн баталгаа ирүүлэх эсэх: <b>“Тийм”</b>

### III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

№	Ажлын нэр төрөл	Тайлбар
1	Ажлын гүйцэтгэх байршил	Дундговь аймгийн Гурвансайхан сум, Чулуут баг, Салхит уурхай
2	Ажил гүйцэтгэх үндэслэл	“Эрдэнэс Алт Ресурс” ХХК-ийн Салхит уулын баяжуулах үйлдвэрийн үндсэн болон туслан гүйцэтгэгч компаниудын ажилчдад хоол үйлдвэрлэлийн /катеринг/ үйлчилгээ үзүүлэх
3	Захиалагч байгууллага	“ЭРДЭНЭС АЛТ РЕСУРС”ХХК
4	Төслийн байршил	<ul style="list-style-type: none"> <li>• Үйлчилгээ үзүүлэх газар нь Улаанбаатар хотоос 300км “Эрдэнэс Алт Ресурс” ХХК-ийн Дундговь аймгийн Гурвансайхан сумын нутагт орших MV-021483 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай хамаарна.</li> <li>• Ажлын талбайтай газар дээр нь очиж танилцаж болох ба танилцах зардлыг тендерт оролцогч өөрөө хариуцна.</li> <li>• Ажлын талбайтай танилцах уулзалтыг захиалагч зохион байгуулахгүй.</li> </ul>
5	Шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангахыг нотлох бусад баримт	<p>Тендерийн үнэ нь 1 жилийн хугацаанд үзүүлэх нийт үйлчилгээний үнэ байна. Тендерийн үнэд хоол хүнсний багцын /нэг өдрийн/ үнийг ирүүлэх ба бусад угаалга цэвэрлэгээний материал, ажилчдын цалин бүх төрлийн татвар хураамж, даатгал, төлбөр тээвэр <b>/хүнс тээвэр болон гарсан хог хаягдлыг тээвэрлэх зардал/</b> болон бусад холбогдох зардлыг тооцож задаргаа тус бүрээр албан ёсны тамга тэмдэг дарж гарын үсэг зурж баталгаажуулан ирүүлнэ. Уурхайд байрлах захиалагч талын ажилчдын тоо <b>76</b> байна.</p> <p>Доорх бичиг баримтыг нотлох материал баримтын хамт бүрдүүлнэ.</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Хоол үйлдвэрлэл үйлчилгээний газарт тавигдах MNS 4946:2019 шаардлагыг хангасан байх (Тохирлын гэрчилгээ )</li> <li>2. Үндсэн үйл ажиллагааны хуваарь /хоол, хүнсний хангалт, угаалга, цэвэрлэгээ, аж ахуйн засвар үйлчилгээний хуваарийг тус тусад нь гаргаж ирүүлэх</li> <li>3. Захиалагчийн катерингийн үйлчилгээнд ашиглагдах эрүүл ахуй, чанарын шаардлага хангасан хүнсний барааны жагсаалт</li> <li>4. Түргэн муудах хүнсийг хадгалах, нөөцлөх хөргүүртэй агуулахын мэдээлэл</li> <li>5. Угаалга цэвэрлэгээнд хэрэглэгдэх бараа материалын жагсаалт</li> <li>6. Ээлжийн ажилчдад өгөх дисерт бүтээгдэхүүний жагсаалт. Хүнсний эрүүл ахуйн болон мэргэжлийн хяналтын байгууллагуудын хяналт тогтмол хамрагддаг байх. /Нотлох баримтыг ирүүлэх/</li> <li>7. ХАБЭА-н аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйд нийцсэн хамгаалалтын үйлчилгээний хувцас, тоног төхөөрөмж, хэрэгсэл багажаар ажилтан бүрийг хангасан байх.</li> <li>8. Үйлчилгээтэй холбоотой үйл ажиллагааг хянах, шалгах мэдээлэл солилцох бүртгэл жагсаалт хөтлөх батлагдсан маягтуудтай байх</li> <li>9. Хортон шавьжнаас урьдчилан сэргийлэх устгах хөтөлбөр журамтай түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, мэргэжлийн байгууллагатай устгал хийлгэх гэрээ байгуулсан байх</li> <li>10. Үйл ажиллагаа ажиллах хүчинтэй холбоотой зохих даатгалуудад хамрагдсан байна.</li> </ol>

		11. Ажлын даалгаварт заагдсан шаардлагыг бүрэн хангаж ажиллах тухай албан бичиг ирүүлэх 12. Бараа материал татан авалт, тээвэрлэлтийн журамтай байх																																																
6	Ажиллах хүчин, тэдгээрт тавигдах шаардлага	Дараах мэргэжлийн ажиллах хүчнээр хангагдсан байна. Үүнд:																																																
		<table border="1"> <thead> <tr> <th>№</th> <th>Албан тушаал</th> <th>Хүний тоо</th> <th>Ажилласан жилийн туршлага</th> <th>Мэргэжил мэргэшил</th> <th>Үндсэн ажилтан эсэх</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>1</td> <td>Ерөнхий тогооч</td> <td>1</td> <td>Мэргэжлээрээ 5-аас доошгүй жил</td> <td>Тогооч 1-р зэрэг</td> <td>Тийм</td> </tr> <tr> <td>2</td> <td>Ахлах тогооч</td> <td>2</td> <td>Мэргэжлээрээ 5-аас доошгүй жил</td> <td>Тогооч 1-р зэрэг</td> <td>Тийм</td> </tr> <tr> <td>3</td> <td>Ерөнхий технологич</td> <td>1</td> <td>Мэргэжлээрээ 1-ээс доошгүй жил</td> <td>Мэргэжлийн дипломтой байх</td> <td>Тийм</td> </tr> <tr> <td>4</td> <td>Тогооч</td> <td>4</td> <td>Мэргэжлээрээ 5-аас доошгүй жил</td> <td>Мэргэшлийн үнэмлэхтэй байх</td> <td>Тийм</td> </tr> <tr> <td>5</td> <td>Жолооч</td> <td>1-2</td> <td>Мэргэжлээрээ 5-аас доошгүй жил</td> <td>/В, С/ Ангилалтай байх</td> <td>Тийм</td> </tr> <tr> <td>6</td> <td>Хүнсний эрүүл ахуйч</td> <td>1</td> <td>Мэргэжлээрээ 1-ээс доошгүй жил</td> <td>Мэргэжлийн дипломтой байх</td> <td>Тийм</td> </tr> <tr> <td>7</td> <td>Туслах ажилтан Бэлтгэгч, үйлчлэгч, Нярав</td> <td>20</td> <td>Мэргэжлээрээ 1-ээс доошгүй жил</td> <td>-</td> <td>Үндсэн эсвэл гэрээт</td> </tr> </tbody> </table>	№	Албан тушаал	Хүний тоо	Ажилласан жилийн туршлага	Мэргэжил мэргэшил	Үндсэн ажилтан эсэх	1	Ерөнхий тогооч	1	Мэргэжлээрээ 5-аас доошгүй жил	Тогооч 1-р зэрэг	Тийм	2	Ахлах тогооч	2	Мэргэжлээрээ 5-аас доошгүй жил	Тогооч 1-р зэрэг	Тийм	3	Ерөнхий технологич	1	Мэргэжлээрээ 1-ээс доошгүй жил	Мэргэжлийн дипломтой байх	Тийм	4	Тогооч	4	Мэргэжлээрээ 5-аас доошгүй жил	Мэргэшлийн үнэмлэхтэй байх	Тийм	5	Жолооч	1-2	Мэргэжлээрээ 5-аас доошгүй жил	/В, С/ Ангилалтай байх	Тийм	6	Хүнсний эрүүл ахуйч	1	Мэргэжлээрээ 1-ээс доошгүй жил	Мэргэжлийн дипломтой байх	Тийм	7	Туслах ажилтан Бэлтгэгч, үйлчлэгч, Нярав	20	Мэргэжлээрээ 1-ээс доошгүй жил	-	Үндсэн эсвэл гэрээт
		№	Албан тушаал	Хүний тоо	Ажилласан жилийн туршлага	Мэргэжил мэргэшил	Үндсэн ажилтан эсэх																																											
		1	Ерөнхий тогооч	1	Мэргэжлээрээ 5-аас доошгүй жил	Тогооч 1-р зэрэг	Тийм																																											
		2	Ахлах тогооч	2	Мэргэжлээрээ 5-аас доошгүй жил	Тогооч 1-р зэрэг	Тийм																																											
		3	Ерөнхий технологич	1	Мэргэжлээрээ 1-ээс доошгүй жил	Мэргэжлийн дипломтой байх	Тийм																																											
		4	Тогооч	4	Мэргэжлээрээ 5-аас доошгүй жил	Мэргэшлийн үнэмлэхтэй байх	Тийм																																											
		5	Жолооч	1-2	Мэргэжлээрээ 5-аас доошгүй жил	/В, С/ Ангилалтай байх	Тийм																																											
6	Хүнсний эрүүл ахуйч	1	Мэргэжлээрээ 1-ээс доошгүй жил	Мэргэжлийн дипломтой байх	Тийм																																													
7	Туслах ажилтан Бэлтгэгч, үйлчлэгч, Нярав	20	Мэргэжлээрээ 1-ээс доошгүй жил	-	Үндсэн эсвэл гэрээт																																													
<p>Нийт ажилчид нь эрүүл мэндийн үзлэгт бүрэн хамрагдсан байна. Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/145 тушаал журмын шаардлагыг хангасан эрүүл мэндийн хуудастай байх.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Ээлж бүр мэргэжлийн үнэмлэхтэй нийтийн хоолны ажилчидтай байх 2-оос доошгүй жил ажлын туршлагатай ахлах тогоочтой байна.</li> <li>• Ээлжийн жолооч тухайн компанийн үндсэн ажилтан байх ба тухайн компанид сүүлийн 1 жил НДШ төлсөн байх <ul style="list-style-type: none"> <li>• Үйлчилгээ үзүүлэгч нь ажиллах хүчний асуудлыг хариуцах бөгөөд даатгалд болон хөдөлмөрийн холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллах</li> <li>• Удирдах ажилтан нь тухайн мэргэжлийн чиглэлээр 3 жил доошгүй хугацаанд ажилласан байх</li> <li>• Хоол үйлдвэрлэл үйлчилгээний чиглэлээр 5-аас доошгүй жил ажилласан туршлагатай, цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол өндөр түвшинд хийдэг байх</li> <li>• Мэргэжлийн үнэмлэхтэй хүнсний эрүүл ахуйч ажилтантай байх</li> </ul> </li> </ul>																																																		
7	Цэвэрлэгээ, угаалга үйлчилгээ	<ul style="list-style-type: none"> <li>• Уурхайн оффис кемпийн заал өрөөний цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол хугацаанд хийж гүйцэтгэнэ.</li> </ul>																																																

		<ul style="list-style-type: none"> <li>• Уурхайд болон шинээр бүтээн байгуулалтаар хийгдэх объект, зам, гудамж талбайн цэвэрлэгээ үйлчилгээг хариуцан ажиллах</li> <li>• Ажилчдын хувцсыг технологийн дагуу тогтмол угаах, индүүдэх, хатаах ажлыг гүйцэтгэнэ.</li> <li>• Ажилчдын цагаан хэрэглэл, дэвсгэр, хөнжил дэрийг тогтмол хугацаанд угааж цэвэрлэх</li> </ul>
8	Техник хэрэгслийн мэдээлэл	<p>Дараах түрээсийн болон өөрийн эзэмшлийн тоног төхөөрөмж, машин механизмаар бүрэн хангагдсан байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Хөргүүрт агуулах 50 тонноос дээш</li> <li>• Улаанбаатар уурхайн чиглэлд тээвэрлэлт хийх стандартын шаардлага хангасан хөргүүртэй тээврийн хэрэгсэлтэй байх</li> <li>• Хог хаягдал зөөвөрлөх тээврийн хэрэгсэлтэй байх</li> <li>• Ээлжийн ажилчдыг зөөвөрлөх тээврийн хэрэгсэлтэй байх</li> </ul>
9	Аюулгүй байдал	<ul style="list-style-type: none"> <li>• ХАБЭА-н дүрэм журам өдөр бүрийн батлагдсан зааварчилгаатай байх</li> <li>• Үйлчилгээтэй холбоотой үйл ажиллагааг хянах мэдээлэл солилцох бүртгэл жагсаалт хөтлөх маягттай байх</li> <li>• Хортон шавьжаас урьдчилан сэргийлэх устгах хөтөлбөр журамтай байх</li> </ul>
10	Ажил гүйцэтгэх хугацаа	Гэрээ байгуулагдсан өдрөөс хойш <b>нэг жил</b> байна.

#### **IV БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ҮНЭЛГЭЭНД ХАРГАЛЗАХ НЭМЭЛТ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД**

Өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 32.1-д үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт ашиглахаар заасан бол захиалагч тендерийн үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг үлдээж бусад шалгуур үзүүлэлтийг хасна.

Энэ бүлэг нь ТШЗ-ны зүйл бөгөөд захиалагч өгөгдлийн хүснэгтэд тусгайлан зөвшөөрсөн бол тендерийн үнэлгээ хийхэд тендерийн маягтад тусгасан үнийн саналаас гадна энэ хэсэгт заасан нэг буюу хэд хэдэн шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлэн, тендерийн үнийг хийсвэрээр нэмэгдүүлэх замаар тендерийн харьцуулах үнийг тодорхойлон үнэлгээ хийх зорилгоор ашиглана.

*Захиалагч энэ хэсэгт зааснаас өөр шалгуур үзүүлэлтийг үнэлгээнд харгалзахгүй.*

- 1. Үйлчилгээ дуусгах хугацаа: **["Ашиглахгүй"]***
- 2. Үйлчилгээний гэрээний гүйцэтгэлийн дараах үйлчилгээг захиалагчийн заасан газар үзүүлэх боломж: **["Ашиглахгүй"]***
- 3. Байгаль орчинд нөлөөлөх байдал: **["Ашиглахгүй"]***
- 4. Хуульд нийцсэн бусад шалгуур үзүүлэлт: **["Ашиглахгүй"]**,*

## V БҮЛЭГ.ТЕНДЕРИЙН ЖИШИГ МАЯГТ

### Маягт 1.Тендер илгээх маягт

[огноо]

#### **“ЭРДЭНЭС АЛТ РЕСУРС” ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ**

#### **Э.УУГАНБАЯР ТАНАА**

Манай [оролцогчийн нэр] нь танай байгууллагаас зарласан [тендер шалгаруулалтын нэр, дугаар] тендер шалгаруулалтад [үнийн хөнгөлөлт тооцоогүй тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичигт заасан хуваарийн дагуу үйлчилгээ үзүүлэхээр, дор дурдсан нөхцөлийг баталж энэхүү тендер (цаашид “тендер” гэх)-ийг хүргүүлж байна. Үүнд:

1. Тендерийн баримт бичиг, түүнд заасан гэрээний нөхцөл (гэрээний ерөнхий нөхцөл, тусгай нөхцөл, гэрээ баталгаажуулах маягт)-тэй танилцаж, бүрэн хүлээн зөвшөөрч тендер шалгаруулалтад оролцсон.
2. Оролцогч, түүний түншлэлийн гишүүн худалдан авах ажиллагаанд оролцох холбоотой хуулиар хориглосон нөхцөлд хамаарахгүй бөгөөд үүний дотор дараах нөхцөлийг гэрчилж байна:
  - 2.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй;
  - 2.2. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, түүний эцсийн өмчлөгч, хөрөнгө эзэмшигч, хамтрагч, эсхүл эдгээрийг гүйцэтгэж байгаа хувиараа аж ахуй эрхлэгч нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэгт заасан албан тушаал эрхэлж байсан болон эрхэлж байгаа хүн, эсхүл түүнтэй хамаарал бүхий этгээд биш;
  - 2.3. Захиалагчийн удирдлага, хяналт, захиргаанд ажилладаг албан тушаалтанд ашиг олгодоггүй.
  - 2.4. Оролцогчийг төлөөлж буй этгээд нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3 дахь заалтад заасан хязгаарлалтад хамаарахгүй.
3. Тендертэй холбоотой нотлох баримт, мэдээллийг холбогдох этгээдээс гаргуулах эрхийг захиалагчид үүгээр олгож байна.
4. Тендерт үнийн хөнгөлөлт [**“санал болгоно” эсхүл “санал болгохгүй” гэж бичих**]. [**Хэрэв үнийн хөнгөлөлт санал болгох бол түүнийг хэрхэн хэрэглэх нөхцөл, аргачлалыг бичих**].
5. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер нээснээс хойш [**ажлын 30 ба түүнээс дээш хоногийн тоо**] хоногийн хугацаанд хүчинтэй байна.
6. Тендерийн баримт бичгийн тендер шалгаруулалтын зааварчилгааны 6 дугаар зүйл, 13.4 болон 17.1-д заасныг зөрчсөн, эсхүл тендерт хуурамч баримт бичиг, мэдээллийг хүргүүлсэн бол уг тендерийг илт худал мэдээлэл бүхий тендер гэж тооцохыг хүлээн зөвшөөрч байна.
7. Тендерт санал болгосон үйлчилгээ нь оюуны өмчийн зөрчилгүй, эрхийн болон биет байдлын доголдолгүй болохыг баталж байна.

8. Тендерийг холбогдох журмын дагуу бусад оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч, тендерийг нууцлах аливаа үүргээс захиалагчийг бүрэн чөлөөлж байна.

***[Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд,  
эсхүл түүнээс эрх олгогдсон этгээдийн нэр,  
албан тушаал, гарын үсэг,  
байгууллагын тамга, тэмдэг]:***

***Хаяг:***



**Маягт 2. Ижил төстэй үйлчилгээ үзүүлсэн гэрээний мэдээлэл**

Гэрээний нэр	Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас	Төсөвт өртөг	Хугацаа /эхэлсэн, дууссан/

**Маягт 3.Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл**

Оролцогчийн нэр: <i>[түншлэлийн гишүүн тус бүр бүрэн дуусгавар болсон гэрээ тус бүрээр бөглөнө].</i>	
1.	Захиалагчийн нэр
2.	Гэрээний нэр
3.	Гэрээний дугаар
4.	Гэрээ байгуулсан огноо
5.	Гэрээ дуусгавар болсон огноо
6.	Гэрээний дүн
7.	Гэрээ гүйцэтгэсэн хаяг, байршил
Гэрээнд оролцсон байдал (нэгийг сонгох) <input type="checkbox"/> Үндсэн нийлүүлэгч <input type="checkbox"/> Түншлэлийн гишүүн <input type="checkbox"/> Туслан гүйцэтгэгч	

**Маягт 4.Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл**

Гэрээний нэр	Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас	Төсөвт өртөг	Гэрээ эхэлсэн хугацаа	Хүлээгдэж буй гүйцэтгэлийн хувь, мөнгөн дүнгээр	Дуусах хугацаа

### **Маягт 5. Үйлчилгээг үзүүлэх ажлын хөтөлбөр болон аргачлалын талаарх танилцуулга**

Техникийн тодорхойлолтод тусгагдсан ажлын даалгаврыг гүйцэтгэх аргачлалын талаарх танилцуулга болон хэрэв ажлын даалгаврын талаар гаргах санал, зөвлөмж ирүүлнэ.

### **Маягт 6. Үйлчилгээ үзүүлэх хуваарь**

Техникийн тодорхойлолтод тусгагдсан ажлын даалгаврын дагуу үзүүлэх үйлчилгээг гүйцэтгэх хуваарийг боловсруулж ирүүлнэ.

### **Маягт 7. Хүний нөөцийн мэдээлэл**

<b>Албан тушаал</b>	<b>Ажилтны нэр</b>	<b>Боловсрол, мэргэжлийн ур чадвар</b>	<b>Нийт ажлын туршлага, жилээр</b>	<b>Тухайн албан тушаалд ажилласан туршлага, жилээр</b>

## Маягт 10. Санал болгож буй ажилтны жишиг намтар (сv)

Санал болгож буй албан тушаал: \_\_\_\_\_

Овог, нэр: \_\_\_\_\_

Мэргэжил: \_\_\_\_\_

Төрсөн он, сар, өдөр: \_\_\_\_\_

Тухайн байгууллагад ажилласан жил: \_\_\_\_\_ Иргэншил: \_\_\_\_\_

Мэргэжлийн холбооны гишүүнчлэл: \_\_\_\_\_

Хариуцах ажил: \_\_\_\_\_

Ур чадварын:

*[Хариуцах ажлын чиглэлээр туршлагажсан, сургалтад хамрагдсан байдлыг товч харуулна. Өмнө гүйцэтгэж байсан ижил төрлийн зөвлөх үйлчилгээнд хариуцаж байсан ажил, хугацаа, байршилыг зааж харуулах. Эдгээр мэдээллийг хагас хуудсанд багтааж бичнэ.]*

\_\_\_\_\_

Боловсрол:

*[Мэргэжилтний их, дээд сургууль, коллеж болон бусад эзэмшсэн мэргэжлийн боловсролын байдал, сургуулийн нэрс, оролцсон/дүүргэсэн хугацаа болон хамгаалсан эрдмийн зэргийн хамт нэгтгэж харуулах. Эдгээр мэдээллийг хуудасны дөрөвний нэгт багтааж бичнэ.]*

Ажилласан туршлага:

*[Өнөөгийн байдлаас эхлэн эсрэг дарааллаар ажилласан туршлагыг бич. Сургууль төгссөнөөс хойш ажилласан бүх албан тушаалын нэр, ажил эрхэлсэн хугацаа, ажил олгогч байгууллага, байршил зэргийг бичнэ. Сүүлийн 10 жилийн туршлагын хувьд гүйцэтгэсэн ажил, үйлчилгээ болон шаардлагатай бол харилцагчийн тодорхойлолтыг хавсаргана. Эдгээр мэдээллийг бичгийн 2 хуудсанд багтаан бичнэ.]*

\_\_\_\_\_

Хэлний мэдлэг:

*[Эзэмшсэн хэлний мэдлэгийн түвшинг ярих, унших, бичих тус бүрт онц, сайн, дунд эсхүл муу гэж тодорхойлно.]*

\_\_\_\_\_

Батламж:

Дээрх мэдээлэл нь миний мэдлэг, чадвар, туршлагыг үнэн зөв харуулсан болохыг үүгээр баталж байна.

Мэргэжилтний овог, нэр, гарын үсэг: \_\_\_\_\_ Огноо: \_\_\_\_\_

Эрх бүхий этгээдийн овог, нэр, гарын үсэг: \_\_\_\_\_ Огноо: \_\_\_\_\_

**Маягт 11. Үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн мэдээлэл**

<b>Машин механизм, тоног төхөөрөмжийн нэр, зориулалт</b>	<b>Хүчин чадал</b>	<b>Тоо ширхэг</b>	<b><i>["Өөрийн эзэмшил" эсхүл "түрээс" аль нэгийг бичих]</i></b>

**Маягт 12. Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт**

		<b>Нууцалсан баримт бичиг, мэдээлэл</b>	<b>Хүний эмзэг мэдээлэлд хамаарах хууль зүйн үндэслэл</b>
1.			
2.			
3.			
4.			
5.			

## VI БҮЛЭГ. ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ

Захиалагч, түүнээс томилсон үнэлгээний хороо нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “хууль” гэх)-ийн дагуу тендер шалгаруулалт зохион байгуулж үйлчилгээ үзүүлэхэд энэхүү гэрээний загварыг боловсруулж ашиглана.

Гэрээний ерөнхий нөхцөл (цаашид “ГЕН” гэх) болон гэрээний тусгай нөхцөл (цаашид “ГТН” гэх), гэрээ баталгаажуулах маягт, түүнд заасан бусад баримт бичиг нь хоёр талын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох баримт бичиг болно. Энэ гэрээ нь захиалагчаас ажил, түүнтэй холбогдох бараа нийлүүлэх, үйлчилгээг үзүүлэх харилцааг зохицуулсан жишиг заалтуудыг агуулна. Гэрээний нөхцөлийг боловсруулахад ГЕН-д өөрчлөлт оруулахгүй.

ГТН-ийг тухайн ажлыг гүйцэтгүүлэх нөхцөлд тохируулан ГЕН-ийн холбогдох зүйл, заалтыг тодруулах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах зорилгоор ашиглана. *Гэрээний нөхцөлийг бэлтгэхэд дараахыг анхаарна:*

ГЕН-ийн аль нэг зүйлд тодорхой мэдээллийг ГТН-д тусгахаар заасан бол холбогдох мэдээллийг ГТН-д заавал оруулна. ГЕН-ийн аль нэг зүйл, заалтыг тухайн ажлыг гүйцэтгэхэд хэрэглэхгүй бол энэ тухай ГТН-д тусгах;

1. Гэрээ баталгаажуулах маягтад шалгарсан тендер оролцогчийн мэдээлэл болон “хамгийн сайн” үнэлэгдсэн тендерийн мэдээллийг тусгах;
2. Гэрээний үнийг тендерийн үнэд залруулга болон хөнгөлөлтийг тооцох бол түүнийг тооцож, нэг валютад хөрвүүлсний дараах үнээр тогтоох;
3. Гүйцэтгэх ажил, дагалдах бараа, үйлчилгээний дэлгэрэнгүй тодорхойлолт, зураг зэргийг гэрээнд хавсаргах;
4. ГЕН, ГТН болон холбогдох хавсралтууд нь өөр хоорондоо зөрчилдөөнгүй байх;
5. Гэрээ баталгаажуулах маягтын хаалтан дотор бичсэн жишээ, зааврыг тендер шалгаруулалтын үр дүнд шалгарсан тендерийн нөхцөлд тохирох үг, өгүүлбэр, тоо хэмжээ зэргээр тусгана. Зарим жишээ нөхцөлийг зөвхөн санаа өгөх зорилгоор оруулсан ба тухайн гэрээний онцлогийг харгалзан захиалагч эцэслэнэ.
6. Гэрээний зүйл болон бусад хэсгийн гарчиг нь гэрээний нөхцөлийн утга агуулгыг тайлбарлах үндэслэл болохгүй.

# ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

## НЭГ. ТОДОРХОЙЛОЛТ БА ТАЙЛБАР

### Тодорхойлолт

- 1.1. Энэхүү гэрээнд хэрэглэсэн үг, хэллэг, илэрхийлэл дор дурдсан утгыг агуулна:
  - 1.1.1. “Захиалагч” гэж Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;
  - 1.1.2. “Захиалагчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлахаас бусад Гэрээтэй холбоотой бүх асуудлаар Гүйцэтгэгчтэй харилцах, хяналтыг хэрэгжүүлэх эрхтэй Захиалагчаас томилогдсон этгээдийг;
  - 1.1.3. “Гүйцэтгэгч” гэж гэрээ байгуулах эрх авсан бөгөөд Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;
  - 1.1.4. “Гүйцэтгэгчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлахаас бусад Гэрээтэй холбоотой бүх асуудлаар Захиалагчтай харилцах эрхтэй Гүйцэтгэгчээс томилогдсон этгээдийг;
  - 1.1.5. “Талууд” гэж Захиалагч болон Гүйцэтгэгчийг хамтад нь нэрлэснийг;
  - 1.1.6. “Хууль” гэж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг;
  - 1.1.7. “Үйлчилгээ” гэж ажлын даалгавар, техникийн тодорхойлолтод заасан ажлыг;
  - 1.1.8. “Ажлын байр” гэж ажил гүйцэтгэж байгаа газрыг;
  - 1.1.9. “Баталгаат хугацаа” гэж гүйцэтгэсэн ажлыг ашиглах явцад ажилд илэрсэн доголдлыг Гүйцэтгэгч хариуцах хугацааг;
  - 1.1.10. “Гомдлын шаардлага гаргах хугацаа” гэж Захиалагчаас баталгаат хугацаанд илрүүлсэн доголдолтой холбогдуулж Гүйцэтгэгчид шаардлага гаргах хугацааг;
  - 1.1.11. “Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал” гэж талуудын хараа хяналтаас гадуур болсон, урьдчилан таамаглах боломжгүй, гэрээний үүргийг гүйцэтгэх боломжгүй болгох байгалийн гамшиг, Төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтны үйлдэл /эс үйлдэхүй/, гоц халдварт, олон улсын хөл хориот өвчин, цар тахлын улмаас бүх нийтийн хорио цээр тогтоосон нөхцөл байдал бий болохыг ойлгоно.

### Тайлбар

- 1.2. Гэрээг тайлбарлах, хэрэглэхэд дараах журмыг баримтална:
  - 1.2.1. Ганц тоогоор илэрхийлсэн үг нь олон тоон утгыг, олон тоогоор илэрхийлсэн үг нь ганц тоон утгыг илэрхийлж болно.

- 1.2.2. Бүлэг болон зүйлийн гарчиг нь гэрээг системчлэх зорилготой бөгөөд гэрээг тайлбарлахад ашиглахгүй.
- 1.2.3. Зүйл, заалт, үг өгүүлбэрийг энэ гэрээнд заасан нэр томъёог үндэслэн тайлбарлах бөгөөд гэрээнд тайлбарлаагүй тохиолдолд гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлана. Хэрэв гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлах боломжгүй тохиолдолд Иргэний хуульд заасан журмыг баримтлан тайлбарлана.
- 1.2.4. Ерөнхий нөхцөл болон тусгай нөхцөл хоорондоо зөрчилдсөн тохиолдолд тусгай нөхцөлийг баримтална.
- 1.2.5. Гэрээний хэрэгжилтийн явцад харилцах хэл нь Монгол хэл байх бөгөөд гэрээг өөр хэл дээр байгуулснаас хувиуд нь хоорондоо зөрчилдсөн тохиолдолд Монгол хэл дээрх хувийг баримтална.

### **ХОЁР. ЗАХИАЛАГЧ**

- |                        |         |      |   |
|------------------------|---------|------|---|
| Захиалагчийн үүрэг     | нийтлэг | 2.1. | Захиалагч нь ажлын үр дүнг хүлээн авч, гэрээнд заасан хугацаанд үнийг төлнө.  |
|                        |         | 2.2. | Захиалагч хууль тогтоомж болон гэрээнд заасан баримт бичиг, зөвшөөрлийг Гүйцэтгэгчид зохих ёсоор гаргаж өгнө.   |
|                        |         | 2.3. | Захиалагч нь үйлчилгээ авахтай холбоотой гаргаж өгсөн ажлын даалгавар, техникийн нөхцөл зэрэг баримт бичгийн алдаатай холбоотой үр дагаврыг хариуцна. |
| Захиалагчийн төлөөлөгч |         | 2.4. | Захиалагчийг төлөөлөн гүйцэтгэгчтэй харилцах, хяналт тавих төлөөлөгчийг Захиалагч томилно.  |
|                        |         | 2.5. | Захиалагчийн төлөөлөгчийн мэдээллийг Гэрээ баталгаажуулах маягтад заана.  |
|                        |         | 2.6. | Захиалагчийн төлөөлөгч нь төлөөлүүлэгчээс бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр эрх, үүргээ аливаа хэлбэрээр бусдад шилжүүлэхийг хориглоно.                |
| Талбайд зөвшөөрөл      | нэвтрэх | 2.7. | Захиалагч нь ажил эхлэхээс дуусах хүртэлх хугацаанд ажлын талбайд нэвтрэх, үйл ажиллагаа явуулах эрхийг Гүйцэтгэгчид бичгээр олгоно.                  |
|                        |         | 2.8. | Ажлын талбайд нэвтрэх эрх олгоогүйгээс ажил гүйцэтгэх хугацаа хэтрэх болон түүнтэй холбоотой үүссэн аливаа үр дагаврыг Захиалагч хариуцна.            |

### **ГУРАВ. ГҮЙЦЭТГЭГЧ**

- |                     |         |      |  |
|---------------------|---------|------|--|
| Гүйцэтгэгчийн үүрэг | нийтлэг | 3.1. | Гүйцэтгэгч нь ажлыг техникийн тодорхойлолтод заасан шаардлагад нийцүүлэн гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэж, Захиалагчид хүлээлгэн өгнө.   |
|                     |         | 3.2. | Гүйцэтгэгч нь ажлын талбайд ажиллах хүч (удирдах ажилтан, инженер, техникийн ажилтан гэх мэт) болон ашиглаж буй тоног төхөөрөмж, машин механизмын дэлгэрэнгүй жагсаалт, мэдээллийг Захиалагчид өгнө.             |
|                     |         | 3.3. | Ажил гүйцэтгэхэд шаардагдах материал, техник, тоног төхөөрөмж, машин механизм, сэлбэг хэрэгсэл, баримт бичгүүд, Гүйцэтгэгчийн түр ба байнгын ажлын байранд ажиллах ажилтан болон үйлчилгээг гүйцэтгэгч хариуцна. |

- 3.4. Ажлын явцад шаардлагатай ус, хий, цахилгаан холбооны болон бусад хангамжийг Гүйцэтгэгч хариуцна.
- 3.5. Гүйцэтгэгч нь нийт ажлын 20 (хорь) хувиас дээш ажлыг Туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэхгүй байх үүрэгтэй.
- 3.6. Гүйцэтгэгч нь гэрээгээр хүлээсэн эрх, үүргийг бусдад шилжүүлэхгүй байх үүрэгтэй.
- 3.7. Гүйцэтгэгч нь захиалагч, түүний эрх олгосон этгээдийг ажлын талбайд чөлөөтэй нэвтрүүлэх үүрэгтэй.
- Гүйцэтгэгчийн төлөөлөгч 3.8. Гүйцэтгэгч нь Захиалагчтай харилцах эрх бүхий этгээдийг томилж, гэрээ баталгаажуулах маягтад заана.
- 3.9. Гүйцэтгэгчийн төлөөлөгч нь гэрээнд заасан ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай тухайн салбараар мэргэшсэн, дадлага туршлага бүхий хүн байна.
- 3.10. Гүйцэтгэгчийн төлөөлөгч нь төлөөлүүлэгчээс бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр эрх, үүргээ аливаа хэлбэрээр бусдад шилжүүлэхийг хориглоно.
- Техникийн болон ажлын талбайн өгөгдөл 3.11. Захиалагч нь үйлчилгээтэй холбоотой нөхцөл байдлын талаарх өөртөө байгаа бүх өгөгдөл мэдээллийг Гүйцэтгэгчид мэдээллийн журмаар ажил эхлэхээс өмнө өгнө.
- Аюулгүй байдал 3.12. Гүйцэтгэгч ажлын талбайд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Галын аюулгүй байдлын хууль зэрэг хөдөлмөрийн аюулгүй байдалд холбогдох бусад хууль тогтоомж, техникийн зохицуулалт, стандарт, норм ба дүрмийг дагаж мөрдүүлнэ.
- 3.13. Гүйцэтгэгч нь ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангана.
- 3.14. Ажил, түүний бүрэлдэхүүн хэсгийг байгалийн болон бусад хүчин зүйлийн нөлөөллөөс хамгаална.
- 3.15. Ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж ажиллана.
- 3.16. Гүйцэтгэгч нь хөдөлмөрийн аюулгүй байдалтай холбоотой үүссэн аливаа хариуцлагыг бүрэн хариуцна.
- 3.17. Гүйцэтгэгч нь ГЕН-ийн 3.19-3.22-т заасан үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүйгээс үүсэх аливаа үр дагаврыг бүрэн хариуцна.
- 3.18. Ажилд ашигласан эсхүл бий болгосон аюултай, хортой, бохирдсон материал, бодисыг холбогдох хууль тогтоомж, Захиалагчийн шаардлагын дагуу хадгалж, устгана.

#### **ДӨРӨВ. АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА, ЯВЦЫН ТАЙЛАН**

- Ажил эхлэх 4.1. Гүйцэтгэгч нь ГТН-д заасан хугацаанд ажлыг эхлүүлж, ажлын хуваарийн дагуу гүйцэтгэнэ.
- 4.2. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэх дэлгэрэнгүй хөтөлбөр (төлөвлөгөө)-ийг ГТН-д заасан хугацаанд захиалагчийн төлөөлөгчид хүргүүлнэ.
- 4.3. Хөтөлбөрт ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажлыг эхлэхээс дуусах хүртэл ажлын



- үе шатны хугацааг болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан байна.
- 4.4. Хөтөлбөр (төлөвлөгөө)-т өөрчлөлт оруулсан тохиолдолд Захиалагчийн төлөөлөгчид мэдэгдэнэ.
- Хугацаа сунгах 4.5. Гүйцэтгэгч дараах тохиолдолд ажил гүйцэтгэх хугацааг сунгах тухай хүсэлт гаргаж болно:
- 4.5.1. ажлыг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэх боломжгүйд хүргэсэн гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон;
- 4.5.2. холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт шинээр батлагдсан, өөрчлөгдсөн нь ажлын гүйцэтгэлд нөлөөлөхөөр байвал;
- 4.5.3. Захиалагч хугацаандаа төлбөр төлөх үүргээ биелүүлээгүй;
- 4.5.4. Захиалагч зөвшөөрөл, баримт бичиг гаргуулах хүргүүлэх үүргээ зохих ёсоор биелүүлээгүй нь ажлын хугацаанд нөлөөлсөн.
- 4.6. Гүйцэтгэгч хугацаа сунгах хүсэлтийг холбогдох нотлох баримтын хамт Захиалагчид ирүүлнэ.
- 4.7. ГЕН-ийн 4.5.1-т заасан нөхцөл байдал үүссэн болохыг Гүйцэтгэгч нотлох үүрэгтэй.
- 4.8. Захиалагч ГЕН-ийн 4.5-д заасан үндэслэлийн аль нэг нь бүрдсэн тохиолдолд Гүйцэтгэгчийн хүсэлтийг үндэслэн хугацааг сунгаж болно.
- Ажлын явцын тайлан 4.9. Гүйцэтгэгч ажлын явцын тайланг ГТН-д заасан хуваарийн дагуу гаргаж Захиалагчийн төлөөлөгчид хүргүүлнэ.
- 4.10. Явцын тайланд үйл ажиллагаа бүрийн бодит гүйцэтгэлийн хувийг гаргаж, түүнийг төлөвлөсөн хувьтай харьцуулсан харьцуулалт, хийгдээгүй ажил байвал тухайн ажлын талаарх мэдээлэл, хэзээ хийх санал, Захиалагчийн төлөөлөгчийн шаардсан бусад мэдээллийг тусгана.
- 4.11. Гүйцэтгэгч нь ажил, түүний бүрэлдэхүүн хэсгийг ажиллуулж, техник үйлчилгээ хийх, задлах, буцаан угсрах, тохиргоо хийх болон засварлах талаар ашиглалт үйлчилгээний зааварчилгааг Захиалагчид гаргаж өгнө.

#### **ТАВ. ГЭРЭЭНИЙ ҮНЭ БА ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ**

- Гэрээний үнэ 5.1. Гэрээний үнийг гэрээ баталгаажуулах маягтад заана.
- 5.2. Гэрээний үнэд хуулийн 11.11-д заасан үндэслэлээр тохируулга хийх эсэх, тохируулга хийх бол аргачлалыг ГТН-д тусгана.
- 5.3. ГЕН-ийн 5.2-т заасны дагуу үнэ тохируулж, гэрээний үнэ өөрчлөгдсөн тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт орсноос хойш өөрчлөгдсөн үнийг баримтална.
- Урьдчилгаа төлбөр 5.4. Тендер шалгаруулалтын баримт бичигт урьдчилгаа төлбөр олгохоор заасан бөгөөд Гүйцэтгэгч урьдчилгаа төлбөрийн хүсэлт гаргасан бол Захиалагч урьдчилгаа төлбөрийг ГТН-д заасан хэмжээгээр олгоно.
- 5.5. Захиалагч нь урьдчилгаа төлбөрийн баталгааг хүлээн авснаас хойш Гүйцэтгэгчид ГТН-д заасан хугацаанд урьдчилгаа төлбөр олгоно.

- Төлбөрийн нөхцөл
- 5.6. Захиалагч нь төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхийг үндэслэн ГТН-д заасан хугацаанд төлбөрийг төлнө.
  - 5.7. Захиалагч гэрээний үүргийг зохих ёсоор гүйцэтгэсэн тухай баримтын хуулбар хувь болон холбогдох баримтыг төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхэд хавсаргахыг шаардаж болно.
  - 5.8. Гүйцэтгэгчийн хүсэлтээр Захиалагч ажил хүлээлгэн өгөх хугацааг ГЕН-ийн 4.8-д заасны дагуу сунгасан бол сунгагдсан хугацаагаар Захиалагчийн төлбөр төлөх хугацааг сунгагдсан гэж үзнэ.
  - 5.9. Захиалагчийн төлсөн аливаа төлбөрийг ажил, түүний бүрэлдэхүүний хэсгийг хүлээн зөвшөөрсөн гэж үзэх үндэслэл болохгүй.
  - 5.10. Төлбөрийн нэхэмжлэх нь Монгол Улсын Үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэгдсэн байна.
  - 5.11. Захиалагч нь алданги болон бусад төлбөр шаардах эрхтэй бол Гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутгана.

### **ЗУРГАА. БАТАЛГАА БА БАТАЛГААТ ХУГАЦАА**

- |                       |           |  |
|-----------------------|-----------|--|
| Урьдчилгаа баталгаа   | төлбөрийн | 6.1. ГЕН-ийн 5.4-д заасны дагуу урьдчилгаа төлбөр олгохоор бол ГТН-д заасан хэмжээний урьдчилгаа төлбөрийн баталгааг ГТН-д заасан хугацааны дотор хуульд заасан хэлбэрээр, холбогдох маягтын дагуу ирүүлнэ.  |
| Гүйцэтгэлийн баталгаа |           | 6.2. Гүйцэтгэлийн баталгаа гаргуулахаар Өгөгдлийн хүснэгтэд заасан бол Гүйцэтгэгч нь тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн 3 хувийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг холбогдох маягтын дагуу захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ. Төсвийн жил дамжин хэрэгжих гэрээний гүйцэтгэлийн баталгааг Гүйцэтгэгч жил бүр шинэчлэн ирүүлнэ.  |
|                       |           | 6.3. Захиалагч дараах нөхцөл бий болсон тохиолдолд үүргийн гүйцэтгэлийг Гүйцэтгэлийн баталгаагаар үл маргах журмаар хангуулна: <ul style="list-style-type: none"> <li>6.3.1. Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ аливаа шалтгааны улмаас гүйцэтгээгүй;</li> <li>6.3.2. Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй;</li> <li>6.3.3. Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон.</li> </ul> |
|                       |           | 6.4. Захиалагч Гүйцэтгэлийн баталгаагаар үүргийн гүйцэтгэлийг хангуулсан нь Гүйцэтгэгчээс алданги, хохирол шаардах эрхийг хязгаарлахгүй.   |
|                       |           | 6.5. ГЕН-ийн 4.8-д заасны дагуу хугацаа сунгагдсан тохиолдолд Гүйцэтгэгч гүйцэтгэлийн баталгааг мөн хугацаагаар сунгуулна.   |
|                       |           | 6.6. Чанарын баталгаа шаардсан тохиолдолд ГЕН-ийн 6.8-д заасан Чанарын баталгаа гаргаснаар Гүйцэтгэлийн баталгааг чөлөөлнө.  |
| Чанарын баталгаа      |           | 6.7. Үйлчилгээний чанарын баталгааг хангуулах зорилгоор баталгаат хугацаанд Чанарын баталгаа гаргуулж болно. Чанарын баталгаа гаргуулах бол чанарын баталгааны хэмжээг ГТН-д заана.  |
|                       |           | 6.8. Гүйцэтгэгч Чанарын баталгааг хуулийн 42.5-д заасны дагуу баталгаажуулж болно.   |

- 6.9. ГЕН-ийн 6.9-д заасны дагуу баталгаажуулсан тохиолдолд Захиалагч барьцаалсан мөнгийг баталгаанд заасан дүнтэй тэнцэх хэмжээгээр олгоно.
- 6.10. Баталгаат хугацаанд үйлчилгээнд аливаа доголдол илрээгүй бол Чанарын баталгааг чөлөөлнө.
- 6.11. ГЕН-ийн 8.6-д зааснаар Захиалагч доголдлыг арилгасан бол доголдол арилгахтай холбоотой гарсан зардал, хохирлыг суутгаж, баталгаат хугацаа дуусмагц үлдсэн мөнгийг Гүйцэтгэгчид олгоно.
- 6.12. ГЕН-ийн 8.5-д заасны дагуу доголдлыг арилгасан тохиолдолд баталгаат болон гомдлын шаардлага гаргах хугацаа хэвийн үргэлжилнэ.
- 6.13. Ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт баталгаат хугацаа тогтоох бөгөөд баталгаат хугацааг ГТН-д заана.
- 6.14. Захиалагч нь баталгаат хугацаанд илэрсэн доголдлыг арилгуулахыг Гүйцэтгэгчээс шаардах эрхтэй.

### **ДОЛОО. ЭРСДЭЛ БА ДААТГАЛ**

- |                            |           |  |
|----------------------------|-----------|--|
| Бусдад<br>хохирлыг арилгах | учруулсан | 7.1. Үйлчилгээ үзүүлэх хугацаанд Гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгч түүний эрх бүхий этгээдийн аливаа үйлдэл (эс үйлдэхүй)-н улмаас бусдад эдийн болон эдийн бус хохирол (хүний амь нас, эрүүл мэнд) учирсан бол хохирлыг Гүйцэтгэгч хариуцна.  |
|                            |           | 7.2. Захиалагч түүний эрх олгогдсон этгээдийн үйлдэл (эс үйлдэхүй)-н улмаас эдийн болон эдийн бус хохирол (хүний амь нас, эрүүл мэнд) учирсан бол Гүйцэтгэгч хариуцахгүй.  |
| Захиалагчийн<br>эрсдэл     | хүлээх    | <p>7.3. Захиалагч дараах эрсдэлийг хариуцна:</p> <p>7.3.1. Үйлчилгээний үр дүнг захиалагчид шилжүүлснээс хойш ажлын үр дүн Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас гэмтсэн, устсан;</p> <p>7.3.2. гүйцэтгэсэн үйлчилгээг хүлээлгэн өгөх мэдэгдэл өгсөн боловч захиалагч ажлыг хүлээн авах үүргээ биелүүлээгүйгээс ажил, түүний бүрэлдэхүүн хэсэг гэмтсэн, устсан;</p> <p>7.3.3. Захиалагчийн буруутай үйлдэл (эс үйлдэхүй)-н улмаас үйлчилгээ, материал болон тоног төхөөрөмж гэмтсэн, устсан;</p> <p>7.3.4. Захиалагчийн ажлын даалгаврын алдааны улмаас үүссэн аливаа эрсдэл.</p> |
|                            |           | 7.4. Үйлчилгээний доголдлын улмаас захиалагч ажлын үр дүнг хүлээн авахаас татгалзсан бол ажлыг хүлээн авах хүртэлх хугацаанд бий болсон аливаа эрсдэлийг захиалагч хариуцахгүй.  |
| Даатгал                    |           | 7.5. Гүйцэтгэгч нь ажлын явцад учирч болзошгүй эрсдэлийг ажил эхлэх өдрөөс дуусах хүртэл хугацаанд ГТН-д заасан даатгалд даатгуулна.   |
|                            |           | 7.6. Захиалагч болон гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгчийн буруутай үйлдэл (эс үйлдэхүй)-ээс гуравдагч этгээдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөнд учирч болзошгүй хохирлыг Гүйцэтгэгч даатгуулна.  |
|                            |           | 7.7. Гүйцэтгэгч нь даатгалын гэрээ, гэрчилгээний хуулбар хувийг захиалагчийн төлөөлөгчид хүргүүлнэ.  |

- 7.8. Гүйцэтгэгч даатгалын гэрээ, гэрчилгээний хуулбар хувийг ирүүлээгүй бол захиалагч уг даатгалын гэрээг байгуулж, даатгалын хураамжийг Гүйцэтгэгчээс гаргуулна.
- 7.9. Даатгалын нөхцөлийг Захиалагчийн төлөөлөгчийн зөвшөөрөлгүйгээр өөрчлөхийг хориглоно.

### **НАЙМ. ДОГОЛДОЛ, ДАЛД ДОГОЛДОЛ**

- |                        |           |   |
|------------------------|-----------|---|
| Доголдлыг арилгах      | илрүүлэх, | <ul style="list-style-type: none"> <li>8.1. Гүйцэтгэгчээс ирүүлсэн үйлчилгээ, түүний хэсэг нь зөрчил, доголдолгүй байна.</li> <li>8.2. Захиалагчийн төлөөлөгч үйлчилгээний явцад зөрчил, доголдолтой байж болзошгүй аливаа ажилд зөрчил, доголдлыг илрүүлэх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг Гүйцэтгэгчид өгнө.</li> <li>8.3. Захиалагч хүлээж авсан ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт ГТН-д заасан баталгаат хугацааны дотор зөрчил, доголдол илэрвэл гомдлын шаардлага гаргах хугацаа дуусахаас өмнө зөрчил, доголдол арилгах тухай мэдэгдлийг Гүйцэтгэгчид хүргүүлнэ.</li> <li>8.4. Гүйцэтгэгч Доголдол арилгах тухай мэдэгдлийг хүлээн авмагц доголдол арилгах ажлыг эхлүүлнэ.</li> <li>8.5. Доголдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр Гүйцэтгэгч уг зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд өөрийн зардлаар арилгана.</li> <li>8.6. Гүйцэтгэгч зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд арилгаагүй бол Захиалагч өөрийн зардлаар арилгаж болно.</li> <li>8.7. Захиалагчийн гаргасан зардлыг Гүйцэтгэгч үл маргах журмаар төлнө.</li> <li>8.8. Доголдлыг арилгах явцад ажил, түүний бүрэлдэхүүн хэсгийг Захиалагч ашиглаж чадаагүй бол доголдлыг арилгах хугацаагаар баталгаат хугацаа сунгагдана.</li> </ul> |
| Далд доголдол          |           | <ul style="list-style-type: none"> <li>8.9. Ажил хүлээн авсан баримт (акт) үйлдсэн ч ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт илэрсэн, далд доголдол, түүний улмаас үүссэн аливаа үр дагаврыг Гүйцэтгэгч хариуцна.</li> </ul>  |
| Зураг төслийн доголдол |           | <ul style="list-style-type: none"> <li>8.10. Зураг төслийг Захиалагч боловсруулсан бол зураг төсөлтэй холбоотой аливаа асуудал (зураг төслийн үнэн зөв, түүнээс үүссэн ажлын доголдол гэх мэт)-ыг Захиалагч хариуцна.</li> <li>8.11. Гүйцэтгэгч нь өөрийн гүйцэтгэсэн Ажлын зураг төсөл, холбогдох баримт бичгүүд, мэдээлэл ба өгөгдлүүдийн үнэн зөвийг хариуцна.</li> </ul>  |

### **ЕС. ГЭРЭЭГ ЦУЦЛАХ**

- |                         |   |
|-------------------------|---|
| Захиалагч гэрээг цуцлах | <ul style="list-style-type: none"> <li>9.1. Захиалагч дараах үндэслэлээр гэрээг цуцалж болно: <ul style="list-style-type: none"> <li>9.1.1. Гүйцэтгэгч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр үйлчилгээ үзүүлээгүй;</li> <li>9.1.2. Захиалагч үүрэг гүйцэтгэх нэмэлт хугацааг тогтоосон боловч үр дүн гараагүй;</li> <li>9.1.3. Гүйцэтгэгч Гэрээгээр хүлээсэн эрх, үүргийг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн бусдад шилжүүлсэн, бусдаар гүйцэтгүүлсэн;</li> </ul> </li> </ul> |
|-------------------------|---|

- 9.1.4. Гүйцэтгэгч нь тендерт оролцохдоо буюу гэрээг гүйцэтгэх явцдаа авилгийн гэмт хэрэгт холбогдсон нь шүүх болон холбогдох байгууллагаар тогтоогдсон;
  - 9.1.5. ГТН-д заасан алдангийн нийт дүн гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 50 (тавин) хувиас хэтэрсэн;
  - 9.1.6. Гүйцэтгэгч нийт ажлын 20 (хорь)-аас дээш хувийг нэг буюу түүнээс дээш туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлсэн;
  - 9.1.7. Ажил гүйцэтгэх хугацаанд Гүйцэтгэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл дуусаж сунгагдаагүй, түдгэлзүүлсэн, хүчингүй болсон.
  - 9.1.8. Гүйцэтгэгч өөрийн тендерийн давуу эрх тооцуулсан нөхцөлийн дагуу гэрээний үүргийг биелүүлээгүй, эсхүл хуулийн этгээдийн хувьд тус нөхцөлийг хангахгүй болсон.
- Гүйцэтгэгч гэрээг цуцлах
- 9.2. Захиалагч ГЕН-ийн 9.1-д заасан үндэслэлээс гадна хэдийд ч гэрээг цуцалж болно.
  - 9.3. Гүйцэтгэгч дараах үндэслэлээр гэрээг цуцалж болно:
    - 9.3.1. Захиалагч нь гэрээнд заасан үндсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй бөгөөд тогтоосон нэмэлт хугацаанд биелүүлээгүй;
    - 9.3.2. ГТН-д заасан алдангийн нийт дүн гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 50 (тавин) хувиас хэтэрсэн;
    - 9.3.3. Захиалагч нь ажлыг түр зогсоосон нь гүйцэтгэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд сөргөөр нөлөөлөхөөр бол.
- Гэрээг цуцлах журам
- 9.4. Гэрээг цуцлах тал нь нөгөө талдаа үүргийн зөрчлийг арилгах нэмэлт хугацаа тогтоосон мэдэгдэл хүргүүлнэ. Нэмэлт хугацаа нь үүргийг гүйцэтгэх ердийн боломжит хугацаа байна.
  - 9.5. Тогтоосон нэмэлт хугацаанд үүргээ гүйцэтгээгүй эсхүл нэмэлт хугацаа тогтоосон ч үр дүнд хүрэхгүй болох нь илт, ГЕН-ийн 4.8-т зааснаар хугацаа сунгагдсан бол Захиалагч үүрэг гүйцэтгэх нэмэлт хугацаа тогтоохгүй байж болно.
  - 9.6. Нэмэлт хугацаа тогтоох шаардлагагүй, нэмэлт хугацаа тогтоосон мэдэгдэлд хариу ирүүлээгүй эсхүл тогтоосон хугацаанд зөрчлийг арилгаагүй тохиолдолд гэрээг цуцлах тал нь нөгөө талд гэрээг цуцлах мэдэгдэл хүргүүлнэ.
  - 9.7. Гүйцэтгэгч ГЕН-ийн 9.6-т заасан мэдэгдлийг хүлээн авсан бол нэн даруй эсхүл мэдэгдэлд заасан хугацаанд ажлын гүйцэтгэсэн хэсгийг хамгаалах, ажлын талбайг цэвэр аюулгүй нөхцөлд үлдээхэд чиглэснээс бусад цаашид гүйцэтгэх бүх ажлаа зогсоож, Гэрээг цуцлах өдөр хүртэл гүйцэтгэсэн ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт холбогдох баримт бичгүүдийг Захиалагчид баримт (акт үйлдэн)-аар хүлээлгэн өгнө.

- Гэрээг цуцалсны дараах төлбөр
- 9.8. ГЕН-ийн 9.1-д заасны дагуу Гэрээг цуцалсан тохиолдолд Гүйцэтгэгч гэрээг цуцлах өдөр хүртэлх гүйцэтгэсэн ажлын төлбөрийг шаардах эрхтэй.
- 9.9. ГЕН-ийн 9.2-т заасны дагуу Гэрээг цуцалсан тохиолдолд Захиалагч гүйцэтгэгчид дараах төлбөрийг төлнө:
- 9.9.1. Гэрээ цуцлах өдөр хүртэлх гүйцэтгэсэн ажлын төлбөр;
- 9.9.2. Ажлын талбайгаас Гүйцэтгэгчийн тоног төхөөрөмжийг нүүлгэхтэй холбоотой үүссэн зардал;
- 9.9.3. Гэрээг цуцалсантай холбоотойгоор Гүйцэтгэгчээс туслан гүйцэтгэгчид төлөх шаардлагатай болсон аливаа төлбөр;
- 9.9.4. Гүйцэтгэгчээс ажлыг хамгаалах, ажлын талбайг цэвэр, аюулгүй нөхцөлд үлдээхэд зарцуулсан зардал;
- 9.9.5. Гэрээг цуцалсантай шууд холбоотой бусад зардал, учирсан хохирол.

#### **АРАВ. БУСАД ЗААЛТ**

- Мэдэгдэл
- 10.1. Талуудын мэдэгдэл, зааварчилгаа, мэдээлэл болон бусад харилцаа төлөөлөгчөөр дамжина.
- 10.2. Гэрээний үүргийн гүйцэтгэлтэй холбоотой бүх мэдэгдэл (зөвшөөрөл, татгалзал, баталгаа, баталгаажуулалт, нэхэмжлэх, гэрчилгээ, шийдвэр, хүсэлт, захидал үүгээр хязгаарлагдахгүй) нь бичгээр үйлдэгдэнэ.
- 10.3. Мэдэгдлийг биечлэн хүргүүлэх эсхүл баталгаат шуудангаар гэрээ баталгаажуулах маягтад заасан төлөөлөгчийн хаягаар илгээнэ.
- 10.4. Дараах тохиолдолд мэдэгдлийг хүлээн авсанд тооцно:
- 10.4.1. баталгаат шуудангаар илгээсэн тохиолдолд шууданд хийсэн өдрөөр төлбөр төлсөн баримтыг үндэслэн;
- 10.4.2. биечлэн хүргүүлсэн мэдэгдлийг нөгөө талын төлөөлөх эрх бүхий этгээд хүлээн авсан огноогоор, тэмдэглэлийг үндэслэн.
- 10.5. Аль нэг тал нь ажлын газрын хаяг, утас, шуудангийн хаягаа сольсон тохиолдолд нөгөө талдаа нэн даруй бичгээр мэдэгдэнэ.
- 10.6. ГЕН-ийн 10.5-д заасан үүргээ биелүүлээгүйгээс үүсэх үр дагаврыг мэдэгдээгүй тал хариуцна.
- 10.7. Нэн даруй мэдэгдэх шаардлагатай яаралтай мэдэгдлийг ГЕН-ийн 10.2-т зааснаас өөр хэлбэрээр мэдэгдэж болох бөгөөд мэдэгдлийг дараа нь баталгаажуулж бичгээр хүргүүлнэ.

- |   |   |
|---|---|
| Төлөөлөгч өөрчлөгдөх  | <p>10.8. Талууд төлөөлөгчийг өөрийн санаачилгаар өөрчилж болно.</p> <p>10.9. Төлөөлөгч өөрчлөгдсөн тохиолдолд нэн даруй нөгөө талдаа бичгээр мэдэгдэнэ.</p> <p>10.10. Мэдэгдэлд төлөөлөгчийн эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, холбоо барих утас (ажлын болон хувийн), цахим шуудангийн хаягийг заавал тусгасан байна.</p> <p>10.11. Төлөөлөгч өөрчлөгдсөн мэдэгдлийг нөгөө талд хүргүүлснээр өмнөх төлөөлөгчийн эрх, үүрэг дуусгавар болно.</p>  |
| Үйлчилгээнд өөрчлөлт, залруулга хийх нөхцөл                   | <p>10.12. Талууд үйлчилгээний чанар, үр ашиг, аюулгүй байдлыг сайжруулах зорилгоор ажлын ерөнхий гүйцэтгэлийн хүрээнд хамаарсан, техник технологийн хувьд боломжтой бөгөөд гэрээний хугацаа, үнэд нөлөөлөхгүй бол ажилд өөрчлөлт оруулж болно.</p> <p>10.13. Гүйцэтгэгч болон Захиалагч өөрчлөлт хийх шаардлагатай гэж үзсэн тохиолдолд өөрчлөлтийн төслийг гүйцэтгэгч гаргана.</p> <p>10.14. Захиалагч төслийг үндэслэн ГЕН-ийн 10.12-т заасан нөхцөл, шаардлага хангасан гэж үзвэл өөрчлөлт хийх мэдэгдлийг хүргүүлнэ.</p> <p>10.15. Захиалагчийн зөвшөөрөлгүй өөрчлөлт хийсэнтэй холбоотой техник, технологийн алдаа гарсан, гэрээний хугацаа хэтэрсэн, үнэ өссөн тохиолдолд үр дагаврыг Гүйцэтгэгч хариуцна.</p>  |
| Гэнэтийн давагдашгүй шинжтэй онцгой байдал буюу хүчний нөхцөл | <p>10.16. Үйлчилгээг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэх боломжгүйд хүргэсэн Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон тохиолдолд Гүйцэтгэгч энэ тухай нэн даруй Захиалагчийн төлөөлөгчид бичгээр мэдэгдэнэ. Бичгээр мэдэгдэх нь хугацаа шаардахаар бол ГЕН-ийн 10.7-д заасан хэлбэрээр урьдчилан мэдэгдэж болно.</p> <p>10.17. Гүйцэтгэгч нь Захиалагчаас зааварчилгаа өгөх хүртэл гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга замыг хайна.</p> <p>10.18. Захиалагч ердийн боломжит хугацаанд зааварчилгаа өгөх бөгөөд талууд харилцан зөвшилцөж гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга хэмжээг авна.</p> <p>10.19. Гэрээг хэрэгжүүлэх захиалагчийн зааварчилгаа, Гүйцэтгэгчийн авсан арга хэмжээ үр дүнд хүрээгүй тохиолдолд Гүйцэтгэгч ГЕН-ийн 4.5-д заасан хүсэлтийг гаргаж болно.</p> |

- Оюуны өмчийн эрх зөрчих 10.20. Үйлчилгээг үзүүлэх явцад болон үйлчилгээ үзүүлсэнтэй холбоотойгоор гуравдагч этгээдийн оюуны өмчийн эрх зөрчигдсэн нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон бол буруутай тал нь хариуцлагыг хүлээж, холбогдон гарах зардал, хохирлыг арилгана.
- Алданги 10.21. Захиалагч нь төлбөр төлөх үүргээ хугацаандаа гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Гүйцэтгэгчид төлнө.
- 10.22. Гүйцэтгэгч нь үйлчилгээг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгээр ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Захиалагчид төлнө.
- 10.23. Талууд гэрээг хэрэгжүүлэх явцад олж авсан хуулиар тогтоосон болон байгууллагаас нууц гэж нууцалж хамгаалалтад авсан аливаа мэдээллийг нөгөө тал зөвшөөрсөн эсхүл эрх бий байгууллага шаардсанаас бусад тохиолдолд гуравдагч этгээдэд задруулахгүй, дамжуулахгүй, нийтэд ил болгохгүй.
- 10.24. Талуудын хувьд нууц мэдээллийг нөгөө талдаа ил болгож байгаа тохиолдолд нууц гэсэн тэмдэглэл хийж, нууцыг задруулахгүй байх мэдэгдлийн хамт өгнө.
- Маргаан шийдвэрлэх 10.25. Гэрээнээс үүссэн аливаа маргааныг талууд харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.
- 10.26. Маргааныг зөвшилцөж, шийдвэрлэж эс чадвал Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.



## ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

<p>ГТН 1. ГЕН 1.1.7 Үзүүлэх үйлчилгээ</p>	<p>Салхит уурхайн бүсэд катерингийн цогц үйлчилгээ /хоол, кемп болон оффисын цэвэрлэгээ, үйлчилгээ/ буюу үйлчилгээг үзүүлнэ. Катерингийн үйлчилгээ нь ажлын даалгаварт зааснаар тодорхойлогдоно. Ажлын даалгавар нь энэхүү гэрээний салшгүй нэг хэсэг байх бөгөөд гэрээний нэгэн адил хүчин төгөлдөр байна.</p>
<p>ГТН 2. ГЕН 1.1.8 Ажил гүйцэтгэх газар</p>	<p>Катерингийн цогц үйлчилгээ, дагалдах үйлчилгээ үзүүлэх газар: <b><i>Дундговь аймгийн Гурвансайхан сумын нутаг дэвсгэрт байрлах Салхит уурхайн бүс</i></b></p>
<p>ГТН 3. ГЕН 3.19. ХАБЭА</p>	<ol style="list-style-type: none"> <li>1. Гүйцэтгэгч, түүний нийт ажилтнууд уурхайн бүсэд ажиллахдаа хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны талаарх холбогдох хууль, дүрэм, журам, стандартууд болон уурхайн дотоод журам, бусад холбогдох журмуудыг дагаж мөрдөнө.</li> <li>2. Гүйцэтгэгч нь Захиалагчийн хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа хариуцсан эрх бүхий ажилтны зааварчилгааг бололцоотой бүх нөхцөлд биелүүлнэ.</li> <li>3. Гүйцэтгэгч тал нь ХАБЭА хариуцсан ажилтантай байх ба өдөр тутамдаа аюулгүй ажиллагааны талаар тогтмол зааварчилгаа өгч ажиллана. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>- Гүйцэтгэж буй ажилд оролцож байгаа бүх ажилтан, ажилчдад аюулгүй ажиллагааны талаар тогтмол зааварчилгаа явуулах</li> <li>- Гүйцэтгэж буй ажилд оролцож байгаа бүх ажилтан, ажилчдыг хамгаалалтын хувцас, хэрэгслээр хангах</li> <li>- Мансууруулах бодис, согтууруулах бодис, согтууруулах ундаа хэрэглэхийг хориглох</li> </ul> </li> </ol>
<p>ГТН 4. ГЕН 4.1. Ажил гүйцэтгэх хугацаа</p>	<p>Ажил эхлэх хугацаа: Талуудын хооронд гэрээ байгуулагдсан өдөр эхлэх бөгөөд холбогдох акт үйлдсэнээр эхэлнэ. Ажил дуусах хугацаа нь гэрээ байгуулагдсан өдрөөс хойш 1 жил байна.</p>
<p>ГТН 5. ГЕН 4.9</p>	<p>Ажлын явцын тайлан гаргах хуваарь болон ирүүлэх хугацаа:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Үйлчилгээ үзүүлэгч талын сар бүрийн ажлын гүйцэтгэлийг нөхцөл нь хувьсах үзүүлэлтүүдээр дүгнэж акт үйлдэнэ.</li> <li>2. Сар бүрийн 05-ны өдөр өмнөх сарын ажлын гүйцэтгэлийг хэлэлцэх тухай тайлангийн хуралд гүйцэтгэгч тал гэрээт ажлын гүйцэтгэлийг тайланг PDF байдлаар үйлдэн тайлагнаж, баримтаар баталгаажуулна.</li> </ol>
<p>ГТН 6. ГЕН 5.2. Үнийн тохируулга</p>	<p>Үнийн тохируулга: <b><i>Хийхгүй.</i></b></p>
<p>ГТН 7. ГЕН 5.4. Урьдчилгаа төлбөр</p>	<p>Урьдчилгаа төлбөр: <b><i>Олгохгүй.</i></b></p>
<p>ГТН 8. ГЕН 7.5. Даатгал</p>	<p>Ажилтнуудаа гэнэтийн ослын даатгалд заавал хамруулах бөгөөд Үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой зохих бүх даатгалд бүрэн хамрагдсан байна.</p>
<p>ГТН 9. ГЕН 5.1. Гэрээний үнэ</p>	<ol style="list-style-type: none"> <li>1. Гэрээнд заагдсан үйлчилгээний нийт үнэ: 963,630,000 төгрөг байна.</li> <li>2. Катеринг үйлчилгээ нийт үнэ 1 хүний өдрийн ..... төгрөг /НӨАТ багтсан дүн болно/</li> </ol>

	<p><b>3. Үнийн задаргаа:</b></p> <p><b>А. Хоол</b></p> <p>А.1 Өглөөний хоол /талх, нарийн боов, сонголттой хоол, цай/ – ..... төгрөг /нэг хүн/  А.2 Өдрийн хоол /1, 2-р хоол, ус, ундаа/ – ..... төгрөг /нэг хүн/  А.3 Оройн хоол /2-р хоол, амттан/ – ..... төгрөг /нэг хүн/</p> <p><b>Б. Цэвэрлэгээ</b> – ..... төгрөг /нэг хүн  <b>В. Угаалга</b> – ..... төгрөг /нэг хүн/  <b>Г.Хог хаягдлын зардал</b> .....</p> <p><b>4. Гүйцэтгэгчийн үзүүлсэн үйлчилгээний төлбөрийг сард 1 удаа тооцож төлнө.</b></p> <p><b>5. Гүйцэтгэгчийн 1 сарын хугацаанд хийж гүйцэтгэсэн нийт ажил, үйлчилгээний үр дүнг үнэлж, талууд акт үйлдэж, дүгнэсний дараа Захиалагч нь Гүйцэтгэгчээс ирүүлсэн нэхэмжлэхийг хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор төлбөрийг шилжүүлнэ.</b></p> <p><b>6. Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5-д заасны дагуу “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэж заасан тул ажил гүйцэтгэгч тал нэг сарын хугацаанд хийж гүйцэтгэсэн үйлчилгээний и-баримтын нэхэмжлэхийг илгээж, баталгаажуулсны дараа Захиалагч тал төлбөрийг шилжүүлнэ.</b></p>
<p>ГТН 10. Гүйцэтгэгчийн хариуцах Зардал</p>	<p><b>1. Захиалагч тал нь катерингийн цогц үйлчилгээг үзүүлэх нөхцөлөөр хангаж, шаардлагатай ажлын байр болон, тоног төхөөрөмжийг Гүйцэтгэгчийн эзэмшилд акт үйлдэж хүлээлгэн өгөх бөгөөд хэвийн элэгдэл хорогдлоос бусад гарсан аливаа эвдрэл гэмтэл, засвар үйлчилгээг Гүйцэтгэгч тал өөрийн зардлаар хариуцна.</b></p> <p><b>2. Захиалагч нь катеринг үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах тоног төхөөрөмж, цахилгаан, ус, шатахууны эх үүсвэрээр хангах бөгөөд эдгээртэй холбоотой хэрэглээний төлбөрийг Гүйцэтгэгч тал бүрэн хариуцна.</b></p> <p><b>3. Захиалагч нь доорх төлбөрийг гүйцэтгэгчийн сар бүрийн санхүүжилтээс суутгана.</b></p> <p>- Гал тогооны тоног төхөөрөмж болон бусад эд зүйлс /гал тогооны сандал ширээ гэх мэт бусад зүйлс/-ийн түрээс нэг сарын ..... төгрөг байна.</p> <p><b>4. Туслан гүйцэтгэгч нарт үйлчилгээ үзүүлэхдээ энэхүү гэрээнд заагдсан стандарт шаардлага, үнийн тарифыг мөрдлөг болгоно.</b></p> <p><b>5. Захиалагч талын албан томилолтоор ажиллаж байгаа ажилтнууд болон бусад зочид төлөөлөгч нарыг хоолоор тухай бүр хангах үүрэгтэй бөгөөд энэ тухай акт үйлдэж Захиалагчийн төлөөлөгчөөр гарын үсэг зуруулсан баримтыг үндэслэн холбогдох тооцоог гэрээний мөн үнээр тооцож Захиалагч тал хариуцна.</b></p>
<p>ГТН 11. ГЕН 3. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг</p>	<p><b>1. Сар тутам захиалагч талын ажилтнуудаас “Сэтгэл ханамжийн судалгаа” авч, үр дүнг Захиалагчид танилцуулан, үйл ажиллагаандаа тогтмол сайжруулалт хийх,</b></p> <p><b>2. Хоолны амт чанарын талаар ирүүлсэн санал, гомдлыг Захиалагч талд хүргүүлэх бөгөөд гарсан зөрчлийг нэн даруй арилгаж, зөрчлийг хэрхэн, яаж арилгасан талаарх хариуг ирүүлэх,</b></p>

	<ol style="list-style-type: none"> <li>3. Хоёр талын харилцан зөвшөөрч баталсан цэсний дагуу хоолны үйлчилгээгээр хангах,</li> <li>4. Гэрээний дагуу зохих ёсоор, үнэн зөв, ёс зүйтэй гүйцэтгэх,</li> <li>5. Нэг төрлийн хоолны давтамжийн хугацааг ойртуулахгүйгээр хоолны хэмжээ, стандартад тохирсон орц нормын дагуу гүйцэтгэх,</li> <li>6. Гэрээт ажил дуусахад хүлээлгэн өгсөн гал тогооны тоног төхөөрөмж, бусад эд хогшлыг хэвийн элэгдлээс дордуулахгүйгээр буцаан хүлээлгэн өгөх,</li> <li>7. Гүйцэтгэж буй ажил, үйлчилгээний нөхцөл, шаардлагад тохирсон хөдөлмөр хамгааллын дүрэм, журмыг чанд сахиж ажиллах,</li> <li>8. Хоол, хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хадгалах хэрэглээний сав суулга нь хүнсний зориулалтын, стандарт, шаардлага хангасан материалаар хийгдсэн байх,</li> <li>9. Үйлчилгээ үзүүлэгч нь хоол үйлдвэрлэл, үйлчилгээний үндсэн ажилтантай байх ба шаардлагатай тохиодолд гэрээт /цагийн/ ажилтантай байж болно.</li> <li>10. Үндсэн болон гэрээт ажилтан нь хоол үйлдвэрлэл, үйлчилгээ, хүнсний салбарт мөрдөгдөж буй стандарт, техникийн зохицуулалт, бусад баримт бичиг, дотоод журам, эрүүл ахуйн дадлын дүрмийг дагаж мөрдөх,</li> <li>11. Ажилтнууд нь онцгой нөхцөл байдал үүссэн үед яаралтай арга хэмжээ авах талаар мэдлэгтэй, зааварчилгааны дагуу хариу арга хэмжээ авахад бэлэн байх,</li> <li>12. Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний ажилтан нь хувь хүний ариун цэврийг сахин, үйлчилгээний болон харилцааны ёс зүйг баримтлан ажиллах,</li> <li>13. Захиалагчийн амь нас, эрүүл мэндийн аюулгүй байдлыг хангаж, галын болон хөдөлмөр аюулгүй ажиллагаа, хоолны газрын холбогдох ёс зүйг баримтлан ажиллах,</li> <li>14. Үйлчилгээ үзүүлсний төлбөрийг Захиалагчаас шаардах эрхтэй.</li> <li>15. Гүйцэтгэгч тал нь уурхайн бүсийн хэмжээнд үүссэн ахуйн хог хаягдыг хуваарийн дагуу Гурвансайхан сумын төвлөрсөн хогийн цэг руу тээвэрлэх ажилд машин техникнээр хангах, тээвэрлэх тал дээр хамтран ажиллах,</li> </ol>
<p>ГТН 12. ГЕН 10.22</p>	<p>Үйлчилгээ үзүүлэгчийн төлөх алданги: Алдангийн хувь: <b>хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувиар тооцно.</b></p> <p>Нийт алдангийн хэмжээ нь: Гэрээний үнийн дүнгийн 50 хувь байна.</p>
<p>ГТН 13. Хүний нөөц</p>	<ol style="list-style-type: none"> <li>1. Гүйцэтгэгч нь Салхитын уурхайн бүсэд ажиллах хүний нөөцийн мэдээллийг тухай бүр Уурхайн хүний нөөцийн ажилтанд өгөх үүрэгтэй бөгөөд уурхайн бүсэд ажиллах хугацаандаа Захиалагч талын уурхайн дүрэм, журмыг мөрдөж ажиллах үүрэгтэй.</li> <li>2. Гүйцэтгэгч тал нь гэрээт ажлыг гүйцэтгэхэд ажлын даалгаварт тусгагдсан шаардлагатай мэргэшсэн ажиллах хүч болон техникийн шаардлага хангасан тоног төхөөрөмж, техник хэрэгсэлээр хангагдсан байна.       <ol style="list-style-type: none"> <li>А. Шаардлагатай хүний нөөцийн бүрдүүлэлт           <ul style="list-style-type: none"> <li>- Ерөнхий тогооч – 1</li> <li>- Ахлах тогооч – 2</li> <li>- Ерөнхий технологич – 1</li> <li>- Мэргэжлийн тогооч – 4</li> <li>- Жолооч – 1-2</li> <li>- Хүнсний эрүүл ахуйч – 1</li> <li>- Туслах ажилтан -20 хүртэл</li> </ul> </li> <li>Б. Шаардлагатай машин техник, тоног төхөөрөмж           <ul style="list-style-type: none"> <li>- Хөргүүртэй машин – 1</li> </ul> </li> </ol> </li> </ol>

	<ul style="list-style-type: none"> <li>- Ажилчдын тээврийн хэрэгсэл – 1</li> <li>- Хог хаягдлын машин – 1</li> <li>- Хөргүүртэй агуулах 50тн дээш – 1</li> </ul>
ГНТ 14. Байр	Гүйцэтгэгч нь Захиалагч талын уурхайн бүсэд байрлах кемпэд байрлах ба тухай бүр кемпэд байрласан ажилтнудын тоог Уурхайн кемп хариуцсан ажилтанд бүртгүүлж, Захиалагч талын баталсан тарифын дагуу тооцоо нийлж, сар бүрийн гүйцэтгэлийн төлбөрөөс суутган тооцно.
ГТН 15. Нууцлал	Ажлын үр дүнд бий болсон аливаа бичиг баримт, тайлан илтгэл зэрэг нь зөвхөн Захиалагчийн эзэмшилд үлдэхийг Гүйцэтгэгч хүлээн зөвшөөрч байгаа болно. Мөн талууд энэхүү гэрээний хэрэгжилтийн явцад олж мэдсэн нөгөө талын байгууллага, хувь хүний нууцыг түүний зөвшөөрөлгүй бусдад задруулахыг хориглоно. Ийнхүү задруулснаас учруулсан хохирлыг буруутай тал бүрэн хариуцна.
ГТН 16. Байгаль орчин	<p>1. Гүйцэтгэгч нь үйлдвэрлэлийн процессоос гарч буй үйлдвэрлэлийн бохир усыг ил задгайгаар хүрээлэн хаяж, байгаль орчин бохирдуулахгүй байх үүрэгтэй. Ийнхүү бохирдуулсан тохиолдолд үүдэн гарах аливаа хариуцлагыг холбогдох хууль, журамд заасны дагуу гүйцэтгэгч тал бүрэн хариуцна.</p> <p>2. Захиалагч үйлдвэрт ашиглагдах химийн бодис, түүний сав, баглаа, боодлын устгалыг Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль, журамд нийцүүлэн мэргэжлийн байгууллагаар хийж гүйцэтгүүлэх ба үүнтэй холбоотой гарсан бүх зардлыг гүйцэтгэгч тал бүрэн хариуцна.</p>
ГТН 17. Өмчлөх эрх	Үйлчилгээ үзүүлэгчийн ирүүлсэн бүх төлөвлөгөө, тайлан болон бусад баримт бичиг нь Захиалагчийн өмч байна. Үйлчилгээ үзүүлэгч нь эдгээр баримт бичгийн хуулбарыг авч үлдэж болно.

## ГЭРЭЭ БАТАЛГААЖУУЛАХ МАЯГТ

**[Тендер шалгаруулалтын нэрийг бичих]** гэрээ.

Дугаар № **[Тендер шалгаруулалтын дугаарыг бичих]**

.....  
хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэрийг бичих]** (цаашид “Захиалагч” гэх), нөгөө талаас **[гүйцэтгэгчийн нэрийг бичих]** (цаашид “Гүйцэтгэгч” гэх) нь Гүйцэтгэгчийн ирүүлсэн тендерийг хүлээн зөвшөөрч энэхүү гэрээг дараах нөхцөлөөр байгуулав.

Энэхүү гэрээ нь Захиалагч болон Гүйцэтгэгчийн хооронд ажил гүйцэтгэх, дагалдах бараа нийлүүлэх, үйлчилгээ үзүүлэх (цаашид хамтад нь “Үйлчилгээ” гэх) болон үнэ төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

1. Энэ гэрээний дагуу гүйцэтгэх Үйлчилгээний үнэ нь **[гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэлд заасан үнийн дүнг тоогоор болон үсгээр бичих]** төгрөг (цаашид “гэрээний үнэ” гэх) байна. Гэрээний үнэ нь санхүүжилтийн дээд хэмжээ байна.
2. Гэрээний үнийг Гүйцэтгэгч **[Гүйцэтгэгчийн нэрийг бичих]**-ийн харилцах **[Банкны нэрийг бичих]** банкны **[дансны дугаар бичих]** дугаар дансанд шилжүүлнэ.
3. Дор дурдсан баримт бичиг нь цаашид гэрээний хэсэг болно. (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:
  - 3.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
  - 3.2. Гүйцэтгэгч тендер илгээсэн маягт;
  - 3.3. Гэрээний тусгай нөхцөл;
  - 3.4. Гэрээний ерөнхий нөхцөл;
  - 3.5. Гүйцэтгэлийн баталгаа;
  - 3.6. Урьдчилгаа төлбөрийн баталгаа;
  - 3.7. Техникийн тодорхойлолт;
  - 3.8. Үйлчилгээ үзүүлэх хуваарь.
4. Гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлаар талуудыг дараах эрх бүхий этгээдүүд төлөөлнө. Үүнд:
  - 4.1. Захиалагчийн төлөөлөгчийн мэдээлэл  
Эцэг/эх-ийн нэр:

Нэр:  
Албан тушаал:  
Ажлын утас:  
Гар утас:  
Цахим шуудан:

4.2. Гүйцэтгэгчийн төлөөлөгчийн мэдээлэл

Эцэг/эх-ийн нэр:  
Нэр:  
Албан тушаал:  
Ажлын утас:  
Гар утас:  
Цахим шуудан:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг] \_\_\_\_\_  
ТАМГА

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг] \_\_\_\_\_  
ТАМГА

## ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗАРЛАЛ

Огноо: **2024 оны 04 сарын 22-ны өдөр**  
Тендер шалгаруулалтын төрөл: **Үйлчилгээ**  
Тендер шалгаруулалтын нэр: **Катерингийн үйлчилгээ**  
Тендер шалгаруулалтын дугаар: **ЭАРХХК/20240101149**

Нийт төсөвт өртөг: **963,630,000 төгрөг (Есөн зуун жаран гурван сая зургаан зуун гучин мянга)**  
Тендер шалгаруулалтын арга: **Нээлттэй тендер шалгаруулалт**

1. **“Эрдэнэс Алт Ресурс” ХХК** нь тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлага, шалгуур үзүүлэлт хангасан аж ахуй эрхлэгчийг тендер ирүүлэхийг урьж байна.
2. Тендер шалгаруулалт нь дараах багцуудаас бүрдэнэ: **“Үгүй”**
3. Тендерийг **2024 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 11 цаг 00 минут**- аас өмнө тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаар илгээх ба тендерийг **2024 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 11 цаг 30 минут**-д нээнэ.
4. Тендерийн хувилбарт саналыг зөвшөөрөх эсэх: **“Зөвшөөрөхгүй”**
5. Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй эсэх: **“Эрхтэй”**
6. Тендер нь түүнийг нээснээс хойш ажлын 30 ба түүнээс дээш өдрийн хугацаанд хүчинтэй байхаар тендерт заана.
7. Тендерийн баталгаа шаардах эсэх: **“Тийм”** Тендерийн баталгаа шаардах бол тендер шалгаруулалтын баримт бичгийн заасан үнийн бүхий тендерийн баталгааг холбогдох журмын дагуу цахим системээр ирүүлснээр тендер нээх болохыг анхаарна уу.
8. Тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа эсэх: **“Үгүй”**
9. Тендер шалгаруулалтыг хоёр үе шаттай зохион байгуулж байгаа эсэх: **“Үгүй”**
10. Оролцогч цахим системийн үйлчилгээний хураамж төлснөөр тендер илгээх эрхтэй байна.

**Монгол Улс, Улаанбаатар хот 14240 Сүхбаатар дүүрэг 1-р хороо,  
Энхтайваны Өргөн чөлөө, “Блю Скай Тауэр” 607 тоот  
Утас: 75351111 – 1055**